

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-5
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	6-36
<hr/>	
1.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	6-15
2.“Хараат бус шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	16
3.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан	17-36

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны  
05 дугаар сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 20 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, О.Саранчулуун;  
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Х.Болормаа, Т.Мөнхсайхан;  
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, М.Энхцэцэг.

**Нэг.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, М.Нарантуяа-Нара, Д.Рэгдэл, Б.Бейсен нарын тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их хурлын гишүүн Л.Энхнасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал нар хариулж, тайлар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн

*гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**П.Ганзориг:** 1.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь хэсгээс” гэсний дараа “тэр үед 3 хүртэлх насанд нь” гэснийг төслөөс хасах гэсэн саналаар санал хураалгах шаардлагатай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 6  
Бүгд: 20

66.7 хувь буюу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**П.Ганзориг:** 1.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь хэсгээс” гэсний дараа “тэр үед 3 хүртэлх насанд нь” гэснийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 6  
Бүгд: 20

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Хараат бус шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хараат бус шинжээчид нэр дэвшигч Г.Алтанзаяа оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга П.Ганзориг танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Ганзориг:** “Хараат бус шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7  
Бүгд: 21  
66.7 хувь буюу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроор дэмжигдлээ.

*Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, мөн газрын Хяналт-шалгалт, үнэлгээний газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Засгийн газрын ахлах референт Д.Бямбадулам, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Сангийн яамны Дотоод аудит, санхүүгийн хяналт-шалгалт, үнэлгээний газрын дарга Ж.Цогтбаяр, мөн яамны Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эдэнэ, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Б.Бейсен, М.Ганхүлэг, Б.Хэрлэн, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газарын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, М.Ганхүлэг нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8-д заасны дагуу санал хураалт явуулав.*

**П.Ганзориг:** Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлантай холбогдуулан гаргасан Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 7  
Бүгд: 21  
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны гишүүд Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсов.

*Уг асуудлыг 16 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 56 минут үргэлжилж, 30 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 16 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 14 цаг 20 минут

### ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**П.Ганзориг:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн ирж гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 53.3 хувьтай байгаа тул Байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулдаг.

Ингээд ирцийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн, Буланы Бейсен гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Банзрагчийн Түвшин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Доржзодовын Энхтуяа гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн гээд нийт 16 гишүүн маань хуралдаандаа бас хүрэлцэн ирсэн байна аа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Хоёрдугаарт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагч, ажил олгогчийг төлөөлөн гишүүнд төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий хараат бус шинжээчийг томилох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг бас батална.

Гуравдугаарт, Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсоно оо.

Ийм 3 асуудал байгаа. Тэгээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёе оо.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна аа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Д.Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Отгонбилиг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга. Отгонбилиг юу? Отгонбилиг дарга тэнд байна уу тэ? Индэр дээрээс хариулах уу?

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Лутаагийн Энханасан гишүүн танилцуулна аа.

Танилцуулгыг эхэлье.

**Л.Энхнасан:** Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг 2026 оны 5 дугаар сарын 14 болон 15-ны өдрүүдэд явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлдэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороод шилжүүлсэн билээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн төслийг танилцуулах гэсний дагуу чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэг бүрчлэн тусгаж эцсийн хувилбарыг төслийг бэлтгэлээ.

Байнгын хорооны дарга аа, эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх эцсийн хувилбарын төслийг та бүхэнд тараасан болно оо.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**П.Ганзориг:** Танилцуулга хийсэн Энхнасан гишүүнд баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нарантуяа-Нара гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

**А.Ариунзаяа:** Тэгээд шүүмжлэлээс айдаггүйгээрээ мөн түүнчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байсан хүний хувьд заавал анхааруулж хэлэхгүй л бол болохгүй асуудлууд байгаа юм аа.

Яах вэ 1957 оноос хойш энэ олгогдож байгаа эхийн алдрын одонгийн сүүлийн далан жилийн хугацаан дахь энэ хувьсан өөрчлөгдөж байгаа явдал бол мэдээж хүн амаа өсгөх ийм асуудал бол мөн. Ерөнхийлөгчийн Тамгын газар яг одоо энэ одонг олгодог. Аймаг, дүүргийн Засаг дарга нарт тухайн эхчүүд материалаа өгөөд тэгээд Ерөнхийлөгчийн Тамгын газраас одонг өгч байгаа. Одон олгогдсон эхчүүдэд 2 дугаар зэргийн одонд жилийн 200 мянган төгрөг, 1 дүгээр зэргийн одонд жилийн 400 мянган төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам олгодог буюу яг энэ одон авсан ээжүүдэд энэ мөнгийг нь олгох энэ халамжийн сангаас нь мөнгийг нь олгох энэ асуудлыг Хөдөлмөрийн яам хариуцаж байгаа. Тэрнээс биш наана нь олгогдох энэ процесс материал бүрдүүлэлт бүхий л энэ ажлууд дээр бол Ерөнхийлөгчийн тамгын газар, Засаг захиргаа удирдлагын нэгж өөрсдөө хариуцаж байгаа. Нэгэнтээ ийм хууль батлагдаж байгаа болбоос энэ процессыг нь бас тодорхой болгож өгч явахгүй л бол яг энэ олголт дээр нь маш олон ийм гомдлын асуудлууд гарна аа.

Нэгдүгээрт 1 нас хүрсэн хүүхэд гэж одоо өмнөх шалгуур нь юу байсан юм бэ гэхлээр төрүүлсэн таслал өсгөсөн буюу ядаж нэг нас хүртэл нь бүхий л анхаарал халамж, хамгаалал бүхий л энэ гол зорилго нь уг нь бол байсан юм л даа. Одоо тэгэхээр зүгээр төрүүлсэн гэдэг агуулгаар нь явчхаж байна. Тэгэхээр амьгүй төрөлт яах вэ? Төрөлтийн, нялхсын эндэгдэл, нярайн эндэгдэл бас их өндөр байгаад байгаа. Тэгэхээр тэр болгоныг нь төрүүлсэн нь жирэмсэн байгаад л тодорхой хугацаа өнгөрөөд тэгээд төрүүлсэн гэдгээрээ явах юм уу эс үгүй бол одоо ингээд эрүүл мэндийн байгууллагад биш гэртээ малчин нүүдэлчин түмэн хөдөө хээр гэнэт төрвөл яах вэ зэрэг ийм асуудлууд маш ихээр гарна аа. Тэгэхээр энэ дээр процессыг нь бас ойлгомжтой болгож өгөх хэрэгтэй. Мөн түүнчлэн хэд дэх төрөлтийг ер нь авч үзнэ гэж үзэхээр болсон юм бол оо. Дундуур нь нэг төрөлтийн дараах эндэгдлийг үзэх юм бол.

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс хариулах уу? Ариунзаяа гишүүнд нэмэлт минут өгье.

**П.Ганзориг:** Хамгийн сүүлийн төрөлтийг авч үзэх гээд байгаа юм уу дундуур нь эндсэн бол яах вэ гэхчлэн маш олон асуултууд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд 1 удаагийнх олон хүүхэд төрүүлээ гэхэд хэд хэдэн удаа байвал яах вэ гэхчлэн асуултын тэмдэг бол маш их байгаад байгаа. Тэгэхээр энийг бас зохицуулж өгөөрэй, тодорхой болгож өгөөрэй. Ажил гүйцэтгэж байгаа анхан шатанд энэ ямар ч тодорхойгүй байдлаасаа болж маш их бухимдал үүсдэг шүү. Хүүхэд үрчлэлийг одоо бас 3 нас хүртэл нь хүүхдийг үрчилсэн бол хүүхдийг төрүүлсэнтэй нэгэн адил үзэж тухайн хүүхдийг өсгөж л байгаа юм чинь гэж хязгаарласан байсныг 3 нас гэдгийг нь бас авчхаж байгаа юм байна аа. Тэгэхээр 17 настай хүүхдийг өргөж авсан ч адилхан одон олгоод л явах юм байна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого ер нь байгаа юм бол? Яам юу гэж бодож байгаа юм бол?

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс хариулъя. Индэр дээрээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Даваажаргал. Индрийн микрофон.

**Д.Даваажаргал:** Ариунзаяа гишүүний асуултад хариулъя аа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ТНБД Даваажаргал.

Яг одоогийн байгаа зохицуулалтаар бол хамгийн бага нас бага хүүхдийг нэг настай байхад төрүүлсэн хүүхдүүдийнх нь тоогоор одонгийнх нь зэрэглэлийг нь тогтоодог ийм зохицуулалтодоо мөрдөгдөөд явж байгаа. Хуулийн өөрчлөлтөөр бол энэ нэг гэдэг насны хязгаарыг хасчхаж байгаа. Тэгэхээр төрүүлсэн болон өсгөсөн хүүхдийн тоо хэд байхаар ерөөсөө хуулийн 4.6 гэдэг шаардлагаа хангасан тохиолдолд одонгийн асуудал ингээд яригдаад эхэлнэ. Үрчлэлтийн асуудал дээр одоо байгаа хуулиар 3 хүртэлх насны хүүхдийг үрчилж авч өсгөсөн ийм ээлжит одонгийн асуудлыг яригдаж байгаа. Тэгэхдээ энэ 3 гэдэг насыг бол одоо Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлж байгаа хуулиар хасъя гэдэг саналтай байгаа юм байна лээ. Хэрвээ сая Ариунзаяа гишүүний ярьж байгаа шиг эрх зүйн хагас чадамжтай буюу 16 насанд хүрсэн ийм хүүхдүүд үрчлэлтэд орох юм бол мэдээжийн хэрэг энэ одонгийн олгогдож байгаа зардлын хэмжээ тодорхой хэмж хэмжээгээр бас нэмэгдэх хандлага байгаа. Яагаад гэхээр одонгийн мөнгийг тухайн ээж насан туршдаа авч байгаа. 16, 17 настай хүүхдийг нэг удаа үрчилж аваад 3 хүүхэдтэй хүн жишээлбэл өөрийнхөө ах дүүгийнхээ хүүхдийг юм уу өөрийнхөө ойролцоо хүний хүүхдийг өргөөд өөрийнхөө нэр дээр бүртгүүлчих юм бол одонгийн мөнгө авах ийм болзол нь насан туршдаа үүсчхэж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ бол бас төсөв дээр тодорхой хэмжээний бас нэмэлт ачаалал үүсэхийг үгүйсгэхгүй.

Нөгөө талдаа бол яах вэ асран дэмжих харгалзах хүнгүй хагас болон бүтэн өнчин хүүхдийг одоо бас ээжтэй аавтай болгох ийм бодлого нь байхыг үгүйсгэхгүй ээ гэж ингэж харж байгаа.

**П.Ганзориг:** Ариунзаяа гишүүн тодруулъя.

**А.Ариунзаяа:** Тэгэхээр ер нь маш тодорхой болгож өгөөрэй л гэж байгаа юм. Журмаар зохицуулж байгаа бол одоо тэр журмуудаа ч гэсэн маш тодорхой болгож өгөхгүй бол яг гүйцэтгэлийн шатад энэ маш их бухимдал гомдол л ялгаварлыг бас үүсгэнэ ээ. Энэ үрчлэлттэй холбоотой ер нь бол манай Монгол Улс нэн ялангуяа одоо энэ хатуу байх ёстой юман дээрээ бас хатуу байж эцэг, эх нэгэнт болсон юм бол эцэг эхийн үүргийг нь бас үүрүүлдэг хариуцуулдаг байх ёстой. Тэгэхээр энэн дээрээ хүүхдүүд эцэг эхчүүдийнх нь энэ бүртгэл одоо бол цахимжчихсан юм чинь тийм ээ бүхий л үүх түүх юмнууд нь тодорхой байгаа шүү дээ. Үүн дээрээ бол бас эцэг эх нь амьд сэрүүн асран хамгаалагчид нь байгаа бол үүн дээр нь үрчлэлтийн асуудлыг ч гэсэн бас авч үздэг. Тухайн хүүхдээ асрамжийн газар үлдээхээд өөрсдөө хүүхдийн мөнгийг нь аваад зугаалж байдаг эцэг эхчүүд ч гэсэн байдаг шүү дээ. Түүнийг бас журамлаж бид нар 2022 онд бол зогсоож байсан. Тэгэхээр энэ дээр бас анхаараарай. Яам бол зайлшгүй энэ дээр хатуу байх ёстой шүү.

**П.Ганзориг:** Үг хэллээ тэ? Ажлын хэсгээс нэмж мэдээлэл өгөх хариулах юм байгаа юу. Энхнасан гишүүн нэмэлтээр хариулъя.

**Л.Энхнасан:** Би ч өмнө нь бас нөгөө яг гишүүний хувьд бол чуулган дээр хэлсэн байгаа. Энэ гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яам энэ Халамжийн хуулиа мөн Гэр бүлийг хөгжүүлэх хууль, Гэр бүлийн хуульдаа бодлогыг бол энэ хуультай зорилготой уялдах ёстой. Энэ утгаараа ч бас хуулийг хэрэгжиж эхлэх хугацааг бол нэг жилээр бол хойшлуулсан байгаа.

**П.Ганзориг:** Тэр бол гишүүний өөрийн бүрэн эрхийн асуудал учраас. Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

**М.Нарантуяа-Нара:** Өдрийн мэнд хүргэе ээ. Тэгэхээр энэ хуулийн төслийг ер нь бол дэмжиж байгаа. Зарим нэгэн асуудлууд бол байна. Тэрийг бол гишүүд бас тус бүрдээ байр сууриа илэрхийлж байна аа. Ялангуяа нэг нас хүртэл гэх гэсэн энэ зүйл заалтыг хасаж байгаа нь бол маш зүйтэй. Яагаад гэвэл Монгол Улсын 3 сая 600 дахь иргэн төрлөө гээд хүүхдийг төрмөгц хүн амынхаа тоонд бүртгэж эхэлдэг. Түүгээрээ Монгол Улсын иргэн гэж нэрлэдэг. Тэгэхээр зэрэг заавал энэ алдарт эхийн одон авахын тулд хүүхдийг нэг нас хүртэл нь хүлээдэг ийм зүйл зохицуулалтыг бас хасаж байгаа нь бас сайшаалтай. Харин нөгөө талд бас нэг асуудал байна. Монгол Улсын одоо энэ глобал фамили их олон глобал олон улсын гэр бүл олон болж байгаа энэ цаг үед гадаад улсын иргэн Монгол Улсын иргэнтэй ханилаад тэгээд Монгол Улсын иргэн төрүүлээд 4 хүүхэд төрүүлчихсэн. Яг одоо миний гарт энэ Ариуна Цэдэнжапова гээд хүний иргэний ээжийн өргөдөл байж байна л даа. Надад 2026 оны 2 сарын 9-нд өгүүлсэн өргөдөл дээрээ энэ хүн 2002 онд Монгол Улсын иргэн Баярхүүтэй гэр бүл болоод тэгээд 4 хүүхэд төрүүлж өсгөсөн байна. 4 хүүхдийнхээ бүгдийнх нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг ингээд хавсаргаад явуулсан байж байна. 2002, 2016, 2018, 2022 онд 4 хүүхэд төрүүлээд хамгийн бага хүүхэд нь 4 настай ийм иргэн байж байна.

Гэтэл энэ хүнд алдарт эхийн одонг нь олгодоггүй ямар нэгэн зүйл заалт зохицуулалт байхгүй. Энэ хүн тэгэхээр зөвхөн танил талаараа Ерөнхийлөгчийн Тамгын газарт хандах ёстой юу? Эс үгүй бол энэнд зориулсан тусгай хуулийн зүйл заалтыг бий болгох ёстой юу яах вэ гэдэг асуудал байна. Тэгэхээр Монгол иргэнийг Монгол Улсын иргэнийг төрүүлсний энэ шагнал алдар гавьяаны одоо энэ үнэлэмж алдарт эхийн одон байна уу эс үгүй бол Монгол хүн төрөхөд л өгөх шагнал юм уу? Одоо ингээд Монгол Улсад амьдарч байгаа энэ хүн гэр бүлтэйгээ, үр хүүхдүүдээ Монгол Улсад бүгдээрээ Монгол хэлтэй өсөж үржиж байна, Монгол Улсдаа амьдарч байна. Монгол Улсын иргэн гээд хүүхдүүд нь төрсний гэрчилгээ авчихсан байна. Гэтэл энэ тохиолдолд энэ хүний асуудлыг хэрхэн яаж шийдэх вэ? Ийм зүйл зохицуулалт байна уу? Энэ талаар асуумаар байна аа.

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс хариулъя. Индэр дээр Индерийн микрофон.

**Д.Даваажаргал:** Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя аа Даваажаргал. Ер нь бол олон улсад хүүхдийн дөнгөж төрсөн хүүхдийн бүртгэлийн асуудлыг бол цусны болон хөрсний гэсэн 2 зарчмаар шийдээд явдаг. Давхар иргэншилтэй улсын хувьд бол одоо ээж, аавын сонголтоор нь аль улсын иргэн байхаа бол шийддэг. Манай улсын хувьд бол цусны зарчимтай буюу Монгол Улсын иргэн ээж аавын аль нэг нь байгаа тохиолдолд хүүхэд нь Монгол Улсын иргэн байна аа гэдэг ийм зохицуулалттай байгаа. Яг хууль тогтоомжийн бүртгэлийн процессын асуудлыг бол бүртгэлийн байгууллага илүү нарийн тодорхой мэдэх байх. Бид нар яг гэр бүлийн бодлогын хүрээнд бол хүүхдийн харьяаллыг цусны зарчмын дагуу Монгол Улсын иргэн байх боломжтой гэж үзэж байгаа. Яг энэ хэлэлцэж байгаа хуультай холбоотойгоор бол Монгол Улсын иргэний бүртгэлд бүртгэгдсэн Монгол Улсын иргэн хүүхдийн хувьд бол энэ хуулийн концепц үйлчлээд явна. Алдарт эхийн одон авах болзол нөхцөлд нь шалгуурт нь хангагдаад явна аа гэсэн үг.

**П.Ганзориг:** Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

**М.Нарантуяа-Нара:** Тэгэхээр одоо Монгол Улсын иргэн л Монгол Улсын иргэн гэсэн бүртгэлтэй эмэгтэй хүнээс л төрсөн 4 хүүхэд 6 хүүхэд төрөх юм бол

тэрийг алдарт эхийн одон гэж өгнө гэсэн үг үү тэ? Тэгэхээр ер нь бол энэ энэ дээр бас цаашид дэлхий ертөнц хавтгай болж байна маш олон гадаадын иргэнтэй гэр бүл болдог ийм байдлууд зөндөө олон болчихсон. Цаашид бас хэрхэн нэмэгдэхийг бас хэн ч мэдэхгүй. Тэгэхээр зэрэг энэ дээр бас нэг зохицуулах арга хэмжээг бас авах ёстой юм байна л гэж харж байна даа. Тэгээд яах вэ энд нь зориулаад тусгай хууль энэ тэр санаачлаад явах ёстой юу яах ёстой вэ? Тийм болох нь уу?

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс хариулах уу? Энхнасан гишүүн хариулъя.

**Л.Энхнасан:** Яг өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа хууль дээр энэ заалт ороогүй учраас дараа нь дахиж өөр юугаар яах байх л даа. Тэгэхдээ ажлын хэсэг дээрээ бид нар бас энэ асуудлыг ярьж байсан. Бас яг нэг хүнээс ийм гомдол ирсэн. Өргөдөл ирсэн эс үгүй бол гэр гэр бүл болоогүй мөртөө олон жил ингээд бас Монголд амьдраад тэгээд гэр бүл болж чадаагүй хүүхдүүдээ бас энэ эхийн урамшууллыг олгох уу үгүй юу гэдгийг бас ярьж байсан. Тэгэхдээ яг энэ хуулийн хүрээнд бол өнөөдөр энэ хамрагдахгүй байгаа.

**П.Ганзориг:** Болчихсон уу? Бейсен гишүүн, Рэгдэл гишүүн 2-ыг асуулт дээр нэмье. Ирцээрээ юм байлгүй дээ. Рэгдэл гишүүн асуулт асууя.

**Д.Рэгдэл:** Хуулийн өөрчлөлтийг агуулгын үед дэмжиж байгаа. Тэгээд Ариунзаяа гишүүнтэй би санал нэг байгаа юм аа. Энд ерөөсөө нарийн зохицуулалт бүүр зайлшгүй хэрэг болоод байх шиг байгаа юм. Амьд төрөлтийн дараа л ерөнхийдөө хүүхдийн одон авах эрх нээгдэнэ гэсэн үг, шагнал авах эрх нээгдэнэ гэсэн үг. Гэтэл тэр хүүхэд Монгол Улсын хүн амын бүртгэлд орсон байх ёстой гэж би бодоод байгаа юм. Тэгж байж эхийн хувьд бол одоо одон авах эрх нээгдэх ёстой. Монгол Улсын хүн амын бүртгэлд ороогүй, өөрөөр хэлбэл төрсний гэрчилгээ авахаас нь өмнө эрхийг нээчихдээ зэрэг энэ зөрчил гарч ирнэ. Энэ 1 дүгээр асуудал.

Хоёр дахь асуудал. Ингээд энд заасан болзлыг хангаад эхийн одон авах болчихлоо. Эхийнхээ одонг авч явж байгаад нэг хүүхдээ 3 нас хүрэхээс нь өмнө өөр хүнд үрчлүүлээд нөгөө эх дээр одон авах эрх нь нээгдчихвэл энийг яаж зохицуулах вэ? Энэ талаар ажлын хэсэг дээр ер нь ярьсан зүйл байгаа болов уу?

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс индэр дээрээс хариулах уу? Индрийн микрофоныг нээе.

**Д.Даваажаргал:** Рэгдэл гишүүний асуултад хариулъя аа Даваажаргал. Яг одоо байгаа хуулийн зохицуулалт болон энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ асуудлууд огт тусгагдаагүй. Тэгээд тусгагдаагүй учраас яамны зүгээс яаж зохицуулалт хийж явж байгаа вэ гэхээр нэгэнт тэр хүн одон авах эрх нь үүсээд одонгоо авчихсан бол яам одонгийн мөнгө буюу 200 мянга, 400 мянган төгрөгийг нь олгоод явж байгаа. Тэр одон авчихсан хүүхдээ бусдад үрчлүүлсэн тохиолдолд тэр одонгийн мөнгөнөөс хасагдана гэсэн ойлголт байхгүй байгаад байгаа. Ер нь бол зүгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр хэрэгжүүлж байгаа бодлого бол хүн амын тоог өсгөх чиглэлээр бид нар ямар уян хатан бодлогууд байна вэ гээд л бүх талаас нь энэ бодлогуудыг ингээд хүлээцтэй авч хэрэгжүүлээд явж байгаа. Яг хүүхдийн яг тэр одон олгож байгаа асуудал дээр бол яг одоо байгаа хууль бол хамгийн бага хүүхэд нь нэг нас хүрсэн байх шаардлагыг л тавьж байгаа. Тэгэхдээ нөгөө шинжлэх ухаан талаасаа болон хууль зүйн нэр томьёо талаасаа хүн

гэдэг ойлголт бүрэлдэх буюу ураг бүрэлдэж бий болсноор хүүхэд гэж үзнэ ээ гээд хуулийн сургууль дээр болон бусад онолын түвшинд заагаад байдаг.

Тэгэхдээ яг ингээд сая таны ярьж байгаа нарийвчилсан зохицуулалтуудыг нь гаргаж өгөхгүй бол нөгөө эмэгтэй хүн хүүхдээ хэвлийдээ бойжуулж байх явцдаа өөрийнхөө болон ургийнхаа аюулгүй байдлын төлөөс нөгөө хүүхдээ авхуулчих юм бол тэр хүүхдийг бид нар ер нь яг бүртгэлд оруулсан гэж үзэх үү, үзэхгүй юу ч гэдэг юм уу ийм асуудлууд үүсэх бас магадлалтай байгаад байгаа юм.

**П.Ганзориг:** Тодруулъя. Тэгэхдээ сая Рэгдэл гишүүний асуулт байна шүү дээ. Үрчилж авчихсан хүүхэд ээж нь одонгоо авч явж одонгийнхоо эрхийг нээлгэж явж байгаад дахиад шилжчихвэл нөгөө хүүхэд нь үрчлэлээр яах вэ гээд бас тодорхой асуугаад байна шүү дээ. Тэгэхээр энэн дээр бас тодорхой хариулаад явмаар байна. Рэгдэл гишүүн эхлээд тодруулчихъя, та тодруулчих.

**Д.Рэгдэл:** Тэгэхээр энэ зүгээр тэр дүрэм журмаар зохицуулж болох л байх. Тэгэхдээ энэ хуулиасаа давсан журам бол гарахгүй гэдэг нь ойлгомжтой. Тэгэхээр 1 дүгээрт ийм давхардал гарвал шийдэх ёстой энийг яаж зохицуулдаг юм байгаа юм? Яагаад гэвэл нэг ээж 5 хүүхэдтэй байж байгаад хөдөө бол ер нь тиймэрхүү юм болдог шүү дээ. 5 дахь хүүхдээ 3 хүүхдийн ээж дээр бүртгүүлээд тэр ээж дээр эрх үүсчихнэ. 5 дахь хүүхдийг нь үрчилж авсан гэдэг нэрийн доор. Энэ тохиолдолд энэ зохицуулалт байх ёстой. Тэгэхээр 2 ээж зэрэг тэр мөнгө авах авахгүйдээ биш байгаа юм. Мөнгө авах эрх бараг л байхгүй байж байгаад эрхтэй болчихдог. Энэ зохицуулалтыг яаж хиймээр юм гэдэг нэг асуудал.

Хоёр дахь асуудал бол ер нь хүүхэд гараад төрсний гэрчилгээ авч байж энэ хуулийн зохицуулалтад хамарна гэдгийг та нар яаж зохицуулах вэ?

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс хариулъя. Индрийн микрофон.

**Д.Даваажаргал:** Одоо байгаа зохицуулалтаар бол хүүхэд гэдэг ойлголтыг иргэний бүртгэлд бүртгэгдсэнээр хүүхэд гэдэг ойлголт үүсээд нэг ёсондоо нөгөө хуулийнхаа шалгуурыг шаардлагыг хангаж байна гэсэн үг. Тэр таны нөгөө асууж байгаа асуулт дээр бол яалт ч үгүй л 5 хүртэл насанд нь хүүхдээ өсгөчхөөд өөр хүнд үрчлүүлчихсэн тохиолдолд нөгөө хүн нь бас давхар нөгөө одонтой ээжийнхээ шаардлагыг хангаад одонгоо авчихсан бол 2 талд хоёуландаа л одонгийнхоо мөнгийг аваад явж байна аа. 2 тал хоёулаа л одонгоо авч байна аа л гэсэн үг. Тэгээд энийг бол бид нар одоогоор тийм зохицуулсан зохицуулалт байхгүй байгаад байгаа.

**П.Ганзориг:** Хуулийн төсөл дээр бас тодорхой заалт бол байгаа юм байна. Тэгэхээр ажлын хэсгээс Энхнасан гишүүн тодруулаад саяын Рэгдэл гишүүний асуултад хариулчих уу?

**Л.Энхнасан:** Энэ хуулийн 3.1.1-д бол зааснаар 4 болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэг нь 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд үрчлэн авсан хүүхэд нас барсан хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй ээ гэж заасан байгаа. Тэгэхээр яг одоогоор байгаа хуулиудын.

Тэгэхдээ ер нь бол бид нар энийг бас ажлын хэсэг дээрээ нэлээн ярьсан шүү дээ. Тэгээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам өнөө Гэр бүлийг дэмжих

хууль дээрээ нэмэлт, өөрчлөлт оруулаад ер нь цаашдаа энэ эхийг урамшуулах энэ журам дээр бол өөрчлөлт орж 18 нас хүрэх юм бол ер нь энийг цаашдаа өгөхгүй байхаар ингэж тусгаж байгаа гэж ярьж байсан. Тэрийгээ бас яам бас тодорхой.

**П.Ганзориг:** Яамны төлөөллүүд бас энэ гишүүдийн асуултад их тодорхой хариулмаар байна шүү. Тэгэхгүй бол ингээд. Бейсен гишүүн асуулт асууя.

**Б.Бейсен:** Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм аа. Тэгэхдээ Ариунзаяа гишүүн, Рэгдэл гишүүн энэ тэрийн саналыг бас дэмжиж байна. Тэгэхдээ хуулийн зохицуулалтыг нарийвчлан тусгаж өгөхгүй бол бас хэд хэдэн асуудал байгаа. Жишээлбэл төрөхөөс өмнөх декрет авч байгаа, төрсний дараах декретыг халамж авч байгаа улсууд байж байгаа. Урьд нь нэг нас хүртэл гээд байсан сая Рэгдэл гишүүний ярьж байгаагаар улсын бүртгэлд бүртгүүлээд төрсний гэрчилгээ авах ёстой. Гэтэл амьд төрчхөөд төрсний дараа эндчихээр чинь бүх улсууд авчих гээд байна шүү дээ энийг чинь. Энэний зохицуулалтыг яах юм. Нөхөн үржихүйн байгууллага ЭМЯ-аас энийг асуусан уу? Зарим гажигтай хүүхдүүд байдаг, амьдрах чадваргүй. Төрчхөөд нэг 7 хоногийн дараа ч юм уу эндчихдэг асуудал байж байна, 10 хоногийн дараа ч юм уу. Энийг нарийвчлан зохицуулалт хийж өгөхгүй бол болохгүй. Энийг тэр ЭМЯ-ны эх барихынхан нөхөн үржихүйн албаас асууж байгаад та нар хуулийн зөвлөгөө авсан уу гээд.

Хоёр дахь асуудал нэг нас хүрээгүй 6 сард юу өгдөг юм Алдарт эхийн одон. Нэг сар болоод, 2 сар болоод, 3 сар, 7 сар, 8 сар, 11 сар болж байгаад эндсэн Монгол Улсад өчнөөн эх байж байгаа. 1-2, 3 хүүхдээ ч алдчихсан Алдарт эхийн одон авч чадахгүй ингээд явж байгаа улсууд байж байгаа юм. Тэгэхээр чинь энэ улсын хэмжээнд энийг чинь нийгмийн даатгалын байгууллагаас асуусан уу? Ер нь баахан ингээд одон авах одонгийн мөнгөө авах улсууд ороод ирэх юм биш биз. Бид нар түрүүн тооцож үзэхэд 6-7 тэрбумын юу орж ирэх юм байна. хэрвээ тийм олон эх орж ирвэл арван хэдэн тэрбум, хорин хэдэн тэрбум ч юм уу төсөвт дарамт орж ирэх юу байж байна? Хэт халамж хавтгайрчихаар чинь бас болохгүй асуудал байгаа. Энийг бас судалж үзсэн үү?

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс хариулъя. Индрийн микрофон.

**Д.Даваажаргал:** Бейсен гишүүний асуултад хариулъя аа Даваажаргал. Ер нь эрт маргаашийн Засгийн газрын хурлаар манай яамнаас боловсруулж байгаа Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль орж байгаа. Тэгээд энэ хууль дээр бол нарийвчилсан. Түрүүний Рэгдэл гишүүний асуусан асуулт болон бусад энэ гишүүдийн асууж байгаа асуулттай холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг бид нар оруулж ирэхээр төлөвлөөд ажиллаж байгаа. Тэгэхдээ одоо Их Хурлын босго давж орж ирээгүй байгаа хуулийн талаар бол энд танилцуулах нь одоо болохгүй байгаа учраас энэ дээр одоо нарийвчилсан мэдээлэл өгөх боломжгүй байна. Хэрвээ яг энэ хууль батлагдаад явах юм бол хууль санаачлагчдын зүгээс хийсэн төсөв дээр ирэх хүндрэлийг нэг 7 орчим тэрбум төгрөг гэж үзэж байгаа юм байна лээ.

**П.Ганзориг:** Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** Тэгэхээр наад хуулийн төсөлдөө бас тодорхой тусгахгүй бол одоо төрсний дараах декретын хугацаанд амьд байна байвал гэдгийг оруулах юм уу аль эсвэл. Тэгэхгүй боо одоо ингээд хавтгайрсан баахан халамж болчих гээд декретынхээ хугацаанд хүүхэд нь эрүүлжээд аль эсвэл иргэний бүртгэлээр

бүртгүүлээд төрсний гэрчилгээ авсны дараах гээд оруулахгүй бол одоо ингээд замбараагүй юм болчих вий гэдэг дээр санаа зовж байна л даа.

**П.Ганзориг:** Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар энэ гишүүдээс бас зарчмын зөрүүтэй санал гаргасан тохиолдолд нийт Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал гаргаад шаардлагатай гэж үзвэл санал хураалгадаг. Тэгээд Ариунзаяа гишүүнээс зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирсэн. Тийм болохоор саналыг эхлээд Ариунзаяа гишүүн тайлбарлаад. Дараа нь эхлээд энэ санал хураалгах шаардлагатай гэдэг зарчмаар саналаа хураагаад 3-ны 2 хүрсэн тохиолдолд энэ саналын томъёоллыг уншиж санал хураалгах ийм дэгтэй юм байна шүү гэдгийг бас хэлье ээ. Ариунзаяа гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая.

**А.Ариунзаяа:** Би хууль санаачлагч Үүрийнтуяа, Баасанжаргал, Баярбаатар, Уянга, Эрдэнэбат, Эрдэнэболд нарын анхны өөрсдийнх нь санаачилснаар нь ядаж энэ нэг нас хүрсэн гэдэг хэсгийг эхний ээлждээ хүчингүй болгох энэ асуудлаар нь хэвээр нь үлдээгээсэй. Хууль санаачлагчийн өргөн барьснаас илүү өргөжүүлж 3 нас хүртэл нь үрчилж авсан гэдэг энэ заалтыг өргөжүүлж насны хязгаар тавихгүй байгаа нь эргээд тооцоолоогүй ийм асуудлуудыг үүсгэх учраас эхний ээлждээ зүгээр хууль санаачлагчдын анхны энэ төслөөр нь явчхаасай. Энэ 3 нас хүртэл гэсэн энэ хязгаарыг эхний ээлждээ хэвээр нь хадгалаад тэгээд ямар нөлөөллүүд цаашлаад орж ирж байна вэ гэдэг дээр бас илүү сайн ярьж байж болохгүй бол зүгээр юу гэдэг юм сэтгэлийн хөөрлөөр бас хамаагүй ингэж бас явмааргүй байна аа гэсэн л ийм зарчмын зөрүүтэй саналыг гаргаад байгаа юм. Тэгэхээр бас бодолцож яг энэ өвчлөлийн асуудлыг эхний ээлждээ зүгээр яг өмнөх явж байгаа энэ жишгээрээ 3 нас хүртэл энэ үед нь үрчилж авсан гэдгээрээ яваасай гэж энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байгаа юм аа. Ажлын хэсгийн гаргасан энэ хүчингүй болгох гэснийг тэр үед 3 хүртэлх насанд гэснийг хасах энэ саналыг нь буцаах гэдэг юм уу төслөөс хасах ийм санал гаргаж байгаа юм.

Ер нь энэ үрчлэлттэй холбоотой асуудал манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр тэжээгчээ алдсаны тэтгэмж дээр бол бас маш их ярвигтай асуудлуудыг үүсгэдэг. Яагаад гэхээр эцэг эх нь амьд сэрүүн тэгээд хүүхдээ өндөр настай ахмадууддаа эмээ өвөө хүмүүстээ үрчлүүлчхээд тэгээд тэжээгчээ алдсаны тэтгэмжийг авч байдаг. Ийм өв уламжлалаа сахиж өвгөдүүддээ хүүхдээ анхны төрөлт төрсөн хүүхдээ үрчлүүлдэг юм аа гэснээр тайлбарлаж маш олон ийм тэтгэмж авдаг хүмүүс байдаг юм аа. Энийгээ бид нар зохицуулж чаддаггүй. Тэгээд одоо дээрээс одоо энэ хүүхдээр ийм ийм асуудлуудыг үүсгэх гээд байгааг бол үнэхээрийн уучлаарай. Бас үнэхээрийн боломгүй байгаад байна аа. Тэгээд энийг нэг жоохон ухамсартайгаар хүлээж аваач ээ л гэж хүсэж байгаа юм. Тэрнээс би нөгөө хүүхдийг өсгөж төрүүлж байгаа. Мэдээж хүүхдийг үрчилж авч байгаа сайн санааны өнчин өрөөсөн хүүхдийг авч байгаа энэ асуудлыг бол огт үгүйсгэх гэсэнгүй. Гэхдээ яалт ч үгүй бодлогын асуудлыг жоохон нухацтайгаар бас ярих хэрэгтэй байна.

Эхний ээлждээ энэ нэг нас гэдгийгээ хүлээн зөвшөөрөөд, 3 нас одоо хүүхдийн үрчлэлтийг хязгааргүй насны хязгаарыг нь хязгаарлалтгүй болсон асуудлыг нэг эргэж хараад нэг жоохон бодож үзээч ээ л гэсэн ийм санал гаргаж байна аа. Гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

**П.Ганзориг:** Ингээд Ариунзаяа гишүүнээс зарчмын зөрүүтэй санал гарсан тул, болохгүй юм байна. Дэг байхгүй гэж байна. Ариунзаяа гишүүн, Хэрлэн гишүүн санал байсан уу?

Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бол энэ зарчмын зөрүүтэй саналыг хураалгадаг. Тэгэхэд эхлээд бол 3-ны хоёртоо хүрэх ёстой. Тэгэхээр саяын энэ асуудлаар санал хураалт явуулъя аа.

Ингээд гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Бүгд бэлдчихсэн үү?

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь хэсгээс” гэсний дараа “тэр үед 3 хүртэлх насанд нь” гэснийг төслөөс хасах санал гаргасан Ариунзаяа.

Санал хураалт.

Санал хураалтад нийт 20 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж энэ санал маань 3-ны 2-оор дахин санал хураалгахаар дэмжигдлээ.

Одоо санал хураалтыг явуулъя. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу энэ санал хураалгах зарчмын зөрүүтэй санал 3-ны 2-оор дэмжигдсэн тул санал хураалтыг явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь хэсгээс” гэсний дараа “тэр үед 3 хүртэл насанд нь” гэснийг төслөөс хасах. Санал гаргасан Ариунзаяа.

Санал хураалт.

Санал хураалтад нийт 20 гишүүн орсноос 14 гишүүн дэмжиж санал 70 хувиар дэмжигдлээ.

Ингээд асуулт хариулт явагдаж дууслаа. Саналаа хурааж дууслаа. Улсын Их Хурлын гишүүн Үүрийнт Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын 2025 оны 6 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлц үзүүлэг явуулж дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Отгоны Саранчулуун гишүүн танилцуулна.

15.10 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

***“Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагч, ажил олгогчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийг мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий хараат бус шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл***

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Ингээд энэ шинжээчид шинжээч томилох тухай асуудлаар нээлттэй зар Parliament.mn дээр 7 хоногийн өмнө 5 сарын 13-нд тавьсан. Тэгээд энэ хугацаанд нэг хүний материал ирсэн. Тэгээд ирсэн хараат бус шинжээчид материал ирүүлсэн хүнийг бас энд оруулаад ирчихсэн байж байгаа. Г.Алтанзаяа хараат бус шинжээчид нэр дэвшиж байгаа.

Энд ороод ирсэн байна. Ингээд нэр дэвшигчдээс асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Асуулт хариулт явагдаж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Ингээд тогтоолын төслөөр санал хураах тул гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа бэлтгэсэн байна.

“Хараат бус шинжээч томилох тухай” байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хэрлэн гишүүн саналаа хэлье. Төхөөрөмж ажиллахгүй байгаа талаар.

**Б.Хэрлэн:** Төхөөрөмж ажиллаагүй тул төхөөрөмж дээр саатал гарсан тул санал хураалтыг дахин явуулж өгнө үү.

**П.Ганзориг:** Энэ төхөөрөмж бас ажиллахгүй байгаад байх шиг байна. Түрүүнээс хойш уг нь хэлээд байна даа. Энэ төхөөрөмжийг бас техникийнхэн анхаарч ажиллая аа. Ингээд саяын саналыг хүчингүй болгох саналын томъёоллоор санал хураалт.

“Хараат бус шинжээч томилох тухай” байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад нийт 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

15.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

## **Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан**

Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Б.Энхбаяр танилцуулна аа. Энхбаяр сайдын микрофоныг.

**Б.Энхбаяр:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хамаарах 56 шийдвэрийн 289 заалтын биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна аа.

Хяналт шинжилгээ үнэлгээг Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний цахим мэдээллийн санд ирүүлсэн тайлан мэдээллийн өгөгдлийн дата баазыг ашиглаж хийсэн бөгөөд анхан шатын нэгжээс шат дараалсан үнэлгээний тайланд нэгтгэсэн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Энэ үйл явцад яам, агентлаг, орон нутгийн төлөөллийг оролцуулснаас гадна Канадын Мерит төсөл, Юнисеф, Удирдлагын академийн зөвлөхүүдийн арга зүйн дэмжлэг зөвлөмж саналыг тусган ажилласан нь анх удаа бүх шатын оролцоог хангасан арга хэмжээ боллоо. Мөн ажлын бүтээмж үр дүнг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглаж тус Байнгын хороонд хамаарах шийдвэрийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж үзлээ.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 56 шийдвэрийн 289 заалтыг яам, агентлаг, аймаг, нийслэл хэрэгжүүлж ажилласан 70.4 хувьтай байна аа.

Нийтдээ 117 заалт хэрэгжсэн, 146 заалт хэрэгжих шатандаа байна аа. Үүнээс удаашралтай эрчимжүүлэх шаардлагатай 65 заалт, хэрэгжээгүй 10 заалт байгаагаас бүгд удирдлага зохион байгуулалтаас шалтгаалсан байна.

Хугацаатай өгөгдсөн оны төгсгөлд гарсан буюу хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 14 заалт байна. Мөн хэрэгжүүлэх хугацаа, чиг үүрэг тодорхойгүй, зардал, санхүүгийн эх үүсвэр, хийх ажил, зорилго тодорхойгүй, хэмжигдэхүйц биш, байдлаас үүдсэн 2 шийдвэр хэрэгжих боломжгүйгээр дүгнэгдсэн байна.

2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон цаг хугацааны явж ач холбогдолгүй болсон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 117 заалтыг Засгийн газрын хяналт шинжилгээний үнэлгээний мэдээллийн сангаас хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэж Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна аа.

Тайлан тоонд хэрэгжээгүй шийдвэрүүд нь төрийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэгдэхээр байна.

Тухайлбал төрийн байгууллагуудын түвшинд хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдэж чадаагүй салбар хоорондын ажлын уялдаа сул олон удаагийн

бүтцийн өөрчлөлт хийгдсэн, төсөв, хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүй бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна аа.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүн Засгийн газрын агентлагийн дарга аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даа гарсан.

Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж салбар хоорондын уялдааг ханган бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх, Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбарын хөгжлийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж буйг үнэлж, тооцож ажиллах, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт утга агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх, санхүүгийн эх үүсвэрийг тусгах хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах.

Дижитал хяналт их өгөгдөлд суурилсан үнэлгээ хийх, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх, санал боловсруулалт танилцуулах.

Мөн хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зөвлөмж хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг даалгасан. Цаашид Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт шинэчлэлтийн талаар баримтлах бодлогыг эргэн харж, шинэчлэх, сайжруулах үндэслэл бий болсныг харуулж байна.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд анхаарах дараах асуудлууд байна аа.

Үүнд:

Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж Засгийн газрын хяналт, шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим сантай уялдуулах, гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах, хяналтад авах Улсын Их Хурлын Байнгын хороо, Их Хурлын гишүүдийн түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан улирал тутам танилцах боломжтой болох, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилдээ хэрэгжсэн бусад шалтгаанаар хяналтаа засуулах шийдвэр заалтын талаар Засгийн газартай тогтмол хамтарч ажиллах, хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны шийдвэр Засгийн газрын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцах хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоол хэлбэрээр аравжуулах зэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1-д Улсын Их Хурлаас Засгын газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган

эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасан нь цаг хугацааны хувьд үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хангалтгүй байгаа тул хугацааг уян хатан зохицуулах, ажлын бүтээмж, үр дүн нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглах талаар Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолын 4-д хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд их өгөгдөл хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийх үүрэг өгөгдсөн.

Үүний дагуу Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн байдалд анх удаа хиймэл оюун ухааныг ашигласан.

Үүнд:

Монгол Улсын хууль тогтоомж, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын нийт 386 акт, 1978 заалтын хэрэгжилтийн байдал давхардлын асуудлыг нэгтгэн дүгнэж үзлээ.

Монгол Улсын хууль хамрах хүрээний 27 хувь, Улсын Их Хурлын тогтоол 44 Хувь, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 29 хувь гэсэн 3 төрлийн эрх зүйн актыг хамруулсан.

Үүнээс Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж үзлээ. Дүн шинжилгээнээс үзвэл нийт 289 заалтын хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин үүрэгжүүлсэн заалт байхгүй, 40.1 хувь нарийн тодорхойлолтоор 7.6 хувь нь тогтоолын хэрэгжилтийг давтан баталгаажуулсан заалт, 5.2 хувь нь бодлогын баримт бичигтэй агуулгын огтлолцол бүхий заалтыг тус тус эзэлж байна аа.

Цаашид хуулиар аль хэдийн ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоолд тусгахаас зайлсхийж Байнгын хорооны тогтоолыг зорилт дээр төвлөрүүлж эрэмбэлэх, тайлагналын горимыг зохицуулж, байгууллагуудын захиргааны давхар ачааллыг бууруулах.

Цаашид тогтоолын заалт боловсруулах үе шатад хиймэл оюун ухааны шинжилгээний аргыг ашиглаж давталт болон бодлогын баримт бичигтэй огтлолцож байгаа эсэхийг урьдчилан шүүж гаргах тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна аа.

Иймд Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийх ажлыг цаашид улам боловсронгуй болгож Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр нөлөө, хяналтыг сайжруулахыг хичээж байна.

Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хамаарах хууль тогтоолын биелэлтийн 2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийг хавсаргасан болно оо. Баярлалаа.

**П.Ганзориг:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Б.Энхбаяр Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга, Ч.Бат-Эрдэнэ ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын дарга, Т.Ням-Очир Боловсролын яамны ТНБД, Даваажаргал Гэр бүл,

хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Н.Эрдэнэбаяр ЭМЯ-ны ТНБД, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД. Батхүү ТНБД байна уу? Байхгүй байна. М.Баяраа Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ж.Цогтбаяр Сангийн яамны дотоод аудит санхүүгийн хяналт шалгалт үнэлгээний газрын дарга, Ш.Цэцэг-Өлзий байна уу? ЗГХЭГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Засгийн газрын ахлах референт, Д.Бямбадулам ЗГХЭГ-ын хяналт ХШҮДАГ-ын ахлах референт, Энхамгалан Соёлын яамны газрын дарга, Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга, Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга, Урьболд Соёлын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүн Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа ажлын хэсгийн үр дүн шинжилгээ шийдвэрийн танилцуулгыг хийнэ ээ. Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

**А.Ариунзаяа:** Бид ер нь хууль, тогтоомжийнхоо дагуу энэ хууль тогтоолоор үйл үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй жил бүр танилцдаг. Тэгээд өөрсдөө ч гэсэн бас энэ үүрэг даалгавраа өгөөд байдаг. Тэгээд энэ биелэлтээ сонсоход дандаа л нэг 40 гаруйхан хувьтай яваад байдагт бас их эргэлзэж өнгөрсөн жилийн намар бас асуулт асуухдаа ер нь өгөгдөөд байгаа үүрэг даалгаврууд нь бас буруу байгаа юм биш биз дээ? Яг юун дээр асуудал байгаад байна вэ гэж асуулт асуугаад Засгийн газрын зүгээс бол тухайн үед Хэрэг эрхлэхийн сайд Учрал дарга байсан. Тэгээд Улсын Их Хурлын эрхэм гишүүдээс ямар л үүрэг даалгавар ирнэ вэ тэрний л бид нар хамаагүй биелүүлэх үүрэгтэй гэж ийм хариулт өгч байсан. Тэгээд энэ бол надаа их яах вэ Засгийн газрын хувьд бол өгч байгаа зөв хариулт байх. Гэхдээ үүрэг даалгавар өгдөг хүмүүсийн хувьд бол энэ маш буруу юм аа гэж хүлээж аваад тэгээд ер нь өөрсдөө ямар үүрэг даалгавар өгөөд байдаг юм бэ гэдгийг хянаж үзье ээ гэж санаачилга гарган та бид хамтдаа 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 4 дүгээр тогтоолоор энэ ажлын хэсэг байгуулсан.

Миний бие ахлаад Баатархүү, Галбадрах, Ганхүлэг, Зулпхар, Рэгдэл, Энхтуяа нар ажилласан. Тэгээд хянаад аваад үзсэн чинь 2017 оны, 2016 оны өгсөн үүрэг даалгаврууд хүртэл өнөөдөр хянагдаад үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнаад явдаг юм байна аа гэдгийг бол харсан. Тэгээд энэ ажлын хэсэг яасан юм бэ гэхлээр тэгвэл энэ хэрэгцээгүй үүрэг даалгавруудаа бид нар хүчингүй болгох ёстой юм байна. Яагаад энийг одоо хүртэл 2017 оны энэ өгсөн үүрэг даалгаврыг биелэлтийг нь дүгнээд тайлагнаад байдаг юм бэ гэдэг ийм асуултыг асуусан. Ингэхэд бол тухайн үүрэг даалгавар өгсөн субъект нь өөрөө энэ үүрэг даалгавраа эргүүлээд энэ хяналтаас гаргах ийм шийдвэр гаргадаг юм аа, ийм журамтай юм аа. Тэрнээс биш өөрсдөө бид нар дур мэдэж энэ хяналтаас гаргаж болдоггүй юм аа гэдэг ийм хариултыг авсан. Тэгмэгцээ бид Байнгын хороогоороо бүрэн хэрэгжсэн гэж үзсэн 16 тогтоолын 64 заалт, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон 14 тогтоолын 24 заалт, хүчингүй болсон 2 тогтоолын 2 заалт, шийдвэрт заасан хугацаа дуусгавар болсон 2 тогтоолын 2 заалт, эрх зүйн орчин шинэчлэгдсэн 5 тогтоолын 16 заалт, нийт манай Байнгын хорооны 39 тогтоолын 108 заалтыг хяналтаас хасна аа гэсэн ийм шийдвэрийг бол гаргасан.

Энэхүү шийдвэрийн талаар мэдээллийг Засгын газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хүргүүлсэн.

Ингээд хүргүүлэхдээ хэрэгжүүлэгч байгууллагуудыг Улсын Их Хурлын шийдвэрийн талаарх тодорхой, ойлгомжтой мэдээллээр хангах, тайлагнах, үйл ажиллагааны давхардал, ачааллыг багасгах, цаг хугацааг хэмнэх, мөн шийдвэрийн бүртгэлийн зөрөөтэй байдлыг арилгах хиймэл оюун ухааныг бас ашиглах зэрэг ийм чиглэлийг өгсөн. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Улсын Их Хурлын шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн биелэлтийн тайлагналт 2025 оны эхний хагас жилийн тайлагналтаас даруй 21-ээс 65 хувиар буюу дотроо хуулийн холбогдох заалт 64 хувиар, Улсын Их Хурлын тогтоолын заалт 21 хувиар, Байнгын хорооны тогтоолын заалт 65 хувиар биелэлт нь сайжирсан буюу бүрэн тайлагнаж орж ирсэн байна аа гэсэн үг.

Шийдвэрийн хэрэгжилтийн түвшин нэмэгдсэн хуулийн эрх олгосон заалтын хэрэгжилт 57 хувиар, Улсын Их Хурлын тогтоол 49.9 хувиар, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт 36.6 хувиар тус тус өссөн нэмэгдсэн байна. Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудаас ирүүлсэн санал болон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан үнэлгээнд үндэслэн бүрэн хэрэгжсэн 31 хуулийн эрх олгосон 148 хэсэг, заалт болон үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын 12 тогтоолын 32 заалт, Байнгын хорооны 12 тогтоолын 20 заалтыг одоо бас бүрэн хэрэгжсэн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон нь тухайн асуудлаар дахин шийдвэр гаргасан зэрэг үндэслэлээр хяналтаас дахин хасах ийм шийдвэрийг дараагийн ээлжид ийм шийдвэрийг оруулж байна аа. Ер нь бол энэ үүрэг даалгаврыг бид нар өгчхөөд түүнийгээ яг хэрэгжүүлэх байгууллагууддаа хүргүүлдэггүйгээс болж энэ хяналтын болон энэ үүрэг даалгаврын хэрэгжилтийн үйл явц бол хоорондоо зөрүүтэй байдаг юм байна аа гэдгийг бол харсан.

Ийм учраас Улсын Их Хурал, Засгийн газар Улсын Их Хурлын харьяа байгууллагууд нэгдсэн 1 платформ дээр энэ үүрэг даалгаврын ийн өгөлт болон үүрэг даалгаврын биелэлтийг нэг системээр хардаг байх, хоорондоо энэ системийн интеграцчилал хийх хэрэгцээ шаардлага байна аа гэдгийг бол хэлээд явж байгаа.

Манай Байнгын хорооны энэ сайн жишгээр бусад Байнгын хороод бас яг өөр өөрсдийнхөө эрхлэх хүрээний асуудлын энэ үүрэг даалгавруудыгаа бас эргүүлж харах энэ хэрэгжилтээс хасах ийм зэрэг ажлуудыг бол эхлүүлээд явж байна. Эхний ээлжид ТББХ ийм ажил ажлын хэсэг бас байгуулаад би энэ Байнгын хорооны гишүүн учраас надаар бас ахлуулсан ийм ажлын хэсэг гаргасан. Бусад Байнгын хороод ч гэсэн энэ манлайллаар адилхан ийм ажлын хэсгүүдийг гаргаад явах байх аа гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Ингэснээрээ одоо яг энэ Засгийн газрын түвшинд өгөгдсөн үүрэг даалгаврын энэ хяналт бол 5, 6 мянган зүйл, заалт дээр энэ тайлангаа тавьдаг юм байна лээ. Тэгэхээр тэр дотроо бол маш олон хугацаа нь дууссан хэрэгжсэн ийм асуудлууд байдаг учраас бас хүмүүсийг тодорхой энэ ажлаа хийх нөхцөлөөр нь хангах ёстой юм аа гэж үзэж байгаа юм аа. Тэгэхээр Байнгын хороо өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд бүрэн хэрэгжсэн шийдвэр заасан хугацаа дууссан үндэслэлээр Байнгын хорооны 12 тогтоолын 20 заалтыг хяналтаас хасах саналтайгаар тогтоолын төслийг боловсруулаад та бүхэнд бас хүргүүлсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 31 хуулийн 148 хэсэг заалт Улсын Их Хурлын 12 тогтоолын 32 заалтыг бас хяналтын бүртгэлээс гаргах

талаар бид нар бас санаачилга гаргах ёстой. Тэгэхээр Байнгын хороо бол Байнгын хорооныхоо өгсөн үүрэг даалгаврыг хяналтаас гаргах ийм тогтоол гаргачихна. Гагцхүү Улсын Их Хурлын тогтоолоор үүрэг даалгавар болгосон асуудлыг бас хяналтаас гаргах ийм асуудал бол цаана нь үлдэж байгаа.

Тэгэхээр түүнийг магадгүй ТББХ бүхий л Байнгын хороодын асуудлуудыг нэгтгээд нэгдсэн нэг Улсын Их Хурлын тогтоол бас санаачилга, хэрэгцээ шаардлага бол гарах байх аа гэсэн ийм бодолтой бол байна аа. Тэгэхээр эхний ээлждээ Байнгын хорооны тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжилтээс хяналтаас хасах ийм саналыг оруулж байгааг дэмжиж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

**П.Ганзориг:** Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Бум-Очир гишүүнээр, Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Бум-Очир гишүүн асуулт асууя.

**Д.Бум-Очир:** Энэ хяналтаас хасагдах гэж байгаа олон зүйл дотор их чухал юмнууд бас их байна аа. Тэгээд ардаа бол дандаа хэрэгжсэн гэдэг ийм дүгнэлттэй явж байна. Яах вэ тодорхой хэмжээнд бол хэрэгжсэн байх аа. Тэгээд энэ дээр би зүгээр жишээ болгоод нэг зүйлийг ярьчихмаар байна. Энэ 2 дугаар хуудсан дээр байгаа хилийн чанад дахь Монгол хүүхдүүдийн хэл соёлын тухай асуудал л даа. Тэгээд энэ үеийн үед цаашдаа ч яригдах ийм асуудал. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Хилийн чанад битгий хэл Монгол Улсад байгаа хүүхдүүд маань Монгол хэлний боловсрол нь жаахан дутмаг байх тухай асуудал ингээд бас том асуудал болоод яригдаад байдаг.

Тэгэхээр цаашдаа энэ чиглэлээрээ нэг 2 юм байгаа.

Нэгд хэрэгжсэн гэдгийг нь яаж яаж, ямар шалгуураар үзсэн юм болоо. Яагаад гэхээр хилийн чанадад байгаа Монголд соёлын төв, сургалтын төвүүдээс одоо дэмжлэг хүссэн маш их хүсэлтүүд ирдэг. Одоо ч ирсээр байгаа. Цаашдаа ч ирэх байх аа. Энэ асуудал бол тэгээд шийдэгдэх ч үгүй асуудал. Гадаадад байгаа Монголчууд бүгдээрээ буцаад ирэхгүй нь тодорхой. Тэгэхээр тэнд байгаа хүүхдүүдийнхээ хэл соёлын асуудлыг бид үргэлжлүүлэн анхаарах шаардлагатай болно. Тэгэхээр энэ дээр би юуг тодруулах гээд байна вэ гэхээр хэрэгжсэн гэдгийг нь ямар шалгуур үндэслэлээр хэрэгжсэн гэххэж байгаа юм бол оо. Цаашдаа энэ асуудлаа Монголын төр засаг тодорхой хэмжээгээр анхаараад үргэлжлүүлээд бодлого гаргаад тодорхой ажлуудыг төлөвлөөд явах шаардлагатай.

Тэгэхээр би бол зүгээр нэг л жишээн дээр асууж байгаа юм шүү гэх мэтчилний өөр зүйлс бас харагдаж байна. Тэгэхээр энэ тал дээр нэг тайлбар өгөхгүй юу?

**П.Ганзориг:** Ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Эхлээд би хариулаад дараад нь яамнаас нэмэлтээр байвал засгаас нэмэлт өгвөл өгөөрэй. Ер нь бол таны саяын асуусан асуудал чинь 2018 оны 10 сарын 16-нд өгөгдсөн ийм үүрэг даалгавар байгаад байгаа. Хүүхэд залуучуудад Монгол ахуй, Монгол өв соёлыг өвлүүлэх, дархлааг бий болгох үүднээс хүүхдүүдэд музейг үнэ төлбөргүй үзүүлдэг байх. Хүүхэд залуучуудын театр, хүүхэддэйн театр, киноны хүрээлэн бүхий чөлөөт цагийн төв цогцолборыг байгуулах ажлыг эхлүүлэх хилийн чанад дахь Монгол хүүхдэд хэл соёлоо өвлүүлэн үлдээх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах гээд.

Тэгэхээр 2018 оны буюу 8 жилийн өмнөх энэ асуудлыг одоо бид нар хэрэгжилтийг нь 1 дүгээрт нэхээд яваад байх нь хэр зохистой байгаа вэ? 1 дүгээрт.

Хоёр дахь нь болохлоор яг биелэлт нь яагаад хэрэгжсэн гэж үзэж байна вэ гэхлээр хилийн чанад дахь Монгол хүүхдэд хэл, соёлоо өвлүүлэн үлдээх чиглэлээр эх хэл, түүх соёлын жишиг сургалтын хөтөлбөрийг БСШУ-ы сайдын 2017 оны А123 тушаалаар баталсан. Монгол хэл, соёлын жишиг хөтөлбөрийн дагуу гадаад дахь хэл соёлын төвүүдэд болон мэдлэг цахим сургуулийн сурагчдаа гэх мэтчилэн ингээд тайлбаруудаа өгчихсөн байгаад байгаа байхгүй юу. Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран 2024 онд бас арга хэмжээнүүдийг зохион байгуулсан, судалгаануудыг хийсэн. Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Соёлын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А32, А55, 56, 151 дүгээр хамтарсан тушаалаар гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын иргэнд эх хэл, бичиг үсэг, үндэстний түүх, соёл, өв уламжлал, зан заншил, соёлын, үнэт зүйлийг таниулахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. Тэгээд үүнийг бол бүрэн хэрэгжсэн гэж үзэж байна аа гэж байгаа юм. Тэгэхээр яах вэ яг өнөөдөр зарим зүйл, заалтууд бол жишээлбэл журам батлах гэсэн заалтуудыг өгсөн байгаа бол журам нь баталчихсан. Гэтэл журмынх нь хэрэгжилт нь ямар байгаа вэ гэдэг чинь өөрөө тусдаа асуудал байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хянаад байгаа асуудал нь бол журам баталсан уу үгүй юу гэдгийг л хянаад байгаа юм. Тэгэхээр энэ заалтуудаа хэрэгжсэнээр нь авч хаагаад харин тухайн заалтуудын хэрэгжилтийг сайжруулах, тухайлсан асуудлаар одоо яг энэ шинэ парламент, энэ Байнгын хороо шинээр өгөөд хугацаатай, биелэгдэхүйц, зөв тодорхой даалгавруудыг өгье өө л гэж байгаа юм.

Тэгэхээр яг энэ агуулгаараа эдгээр 20 заалтыг бол хасъя аа. Энэ бол арай нөгөө арай болохгүй байна аа л гэсэн ийм агуулгатай юм.

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс Боловсролын яам нэмж хариулах уу? Ням-Очир дарга индрийн микрофон дээрээс хариулъя.

**Т.Ням-Очир:** Гишүүний асуултад хариулъя аа. Боловсролын яамны ТНБД Ням-Очир. Тэгэхээр сая Ариунзаяа гишүүн хэллээ. Энэ бол 2018 оны тогтоол. Тэгэхээр 2023 онд Боловсролын багц хуулиуд шинэчлэн батлагдаад хууль эрх зүйн орчин шинэчлэгдсэн. Энэ хүрээндээ хилийн чанад дахь Монгол хүүхдүүдийн хэл, соёлын боловсролын асуудлаар тусгайлсан журам батлах чиг үүрэг нь Боловсролын ерөнхий газар буюу төрийн захиргааны байгууллагад үүрэг болчихсон. Энэ хүрээндээ бол хууль, эрх зүйн орчин шинэчлэгдээд журмууд шинэчлэгдээд хилийн чанад дахь Монгол хүүхдүүдэд хэл, соёлын хөтөлбөр, цахим контент, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн бусад дэмжлэгүүдийг бол энэ журмаар үзүүлээд явж байгаа учраас шинэ хууль эрх зүйн орчныхоо хүрээнд энэ журмууд бас хяналтад ороод ингээд дахиад хэрэгжилт гараад явж байгаа гэж ойлгож болно.

**П.Ганзориг:** Бум-Очир гишүүн тодруулъя.

**Д.Бум-Очир:** Би санал хэлэх гэж байгаа юм аа.

**П.Ганзориг:** Бейсен гишүүн асуулт асууя. Тэгээд Хэрлэн гишүүнийг бас асуултад нэмээрэй.

**Б.Бейсен:** Энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021 оны 10 сарын 19-ний өдрийн 5 дугаар тогтоол байгаа. Энд дотор нь 3 заалттай юм байна л даа.

Нэг нь ЭМД-ын сангаас хариуцах төлбөрийн тухай өрх, сумын, тосгоны эрүүл мэндэд үзүүлэх эмнэлгийн анхан шатын тусламж, үйлчилгээний талаар, 2 дахь нь эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын талаар, нөгөө мэргэжлийн хяналтын албыг тараагаад тэгээд Эрүүл мэндийн газар руугаа тэр байцаагч нарын шилжүүлсэн асуудал.

Гурав дахь нь нийслэл, аймаг, сум, бүх шатын эмнэлгүүдийн салбарын холбогдох хууль тогтоомж болон санхүүжилтийн шинэчлэлийн талаар. Энэ тайлантай танилцлаа л даа. Сургалт л явагдаад байх юм. Гэхдээ энэ бодит хэрэгжилт нь муу байна. Одоо ЭМД-ын сан маань үнэхээр хүнд байдалтай байна. ЭМЯ эрүүл мэнд даатгалын сангаас ЗГ-аас асуухад эмнэлгүүд өргүй байна аа гээд ярьж байгаа юм. Эмийн компаниуд төрд байна гээд. Эмнэлгийн тусламж үйлчилгээ бол тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээ эмтэй байж байж сайн байх ёстой. Гэтэл эмийнх нь өр төлбөр энэ өглөг авлагаа шийдэж чадахгүй байгаа юм чинь. Энэ нийслэл, аймаг, сум, бүх шатны эмнэлгүүд дээр чинь хоёрхон удаа сургалт хийсэн байна л даа 2025 оны 3 сарын 18-нд 84 өдөр ажилтанд, 2025 оны 4 дүгээр тогтоолоор 2025 оны 6 сарын 6-нд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн талаар сургалт хийсэн байна 100 хүнд. Энэний цаана би бас байнга ярьж байгаа. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц орон тоог шинэчилж байж энийг нь шийдэхгүй бол болох гээд асуудал байгаа. Яг эмнэлгийн хороо нь бүтэц, орон тоог нь баталж өгч байгаа. Тэнд Энхбаяр сайд бас анхаарахгүй бол энэ ер нь ЭМЯ, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн яам манай дээр бүтэц орон тоог шинэчилж өгөх гээд илүү орон тоо тавьчихаад эмнэлгийн салбарынхан санхүүжилт авч чадахгүй, урамшуулал авч чадахгүй, тэд нарын илүү цалин НДШ-д явчихаад байна, 1 дүгээрт.

Хоёрдугаарт, ЭМД-ын үндэсний зөвлөлийн шийдвэр гаргачихдаг. Тэрүүгээр хэлэлцээд л байж байдаг. Одоо тэгээд эмийн өр гээд бүүр дэндчихсэн. Хэвтэж байгаа улсууд дандаа гаднаас эм авчирч байна. Эмнэлгийн хэрэгслүүдээ гаднаас авчирч байгаа асуудлууд байж байна. Энэ талаар бодитой юм шийдэж байгаа салбар яамдуудтай ярьсан уу гээд асууя дараа тодруулъя.

**П.Ганзориг:** Ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Дахиад би эхлээд нь хариулаад ажлын хэсгээс дахиад нэмэлтээр аваарай. Бейсен гишүүний яг асууж байгаа асуулт бол ЭМЯ-ны эрхэлж байгаа ажил болон ЭМД-ын ерөнхий газрын явуулж байгаа үйл ажиллагаа өнөөдөр буюу 2026 онд тулгамдсан асуудлуудын талаар бол та асууж энэ дээр анхаарах хэрэгтэй гэдгийг бол хэлж байна шүү дээ тэ? Яг энэ манай ажлын хэсгээс оруулж байгаа хяналтаас гаргах энэ чиглэл нь өөрөө юу юм бэ гэхээр 2021 оны 10 сарын 19-нд өгөгдсөн үүрэг даалгавар тэгээд энэ бол өөрөө хугацаатай өгөгдсөн үүрэг даалгавар буюу яг энэ ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны энэ асуудлыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2 дахин нэмэгдүүлээд ингээд явах гэсэн ийм асуудал байгаа. Үүнийг бол тухайн ЭМД-ын үндэсний зөвлөлийн 2023 оны 6 сарын 28-ны 6 дугаар тогтоол болон 2024 оных гэх мэтчилэн энэ асуудлууд нь шийдэгдээд явчихсан ийм асуудал байна аа. Эм, эмнэлгийн

хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын чиг үүргийг батлагдсан орон тооны дагуу 2021 оны 10 дугаар сард багтаан шилжүүлэх гэсэн ийм үүрэг даалгавар өгөгдсөн. Энэ бол Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор 22 оны 1 дүгээр сараас энэ асуудал нь шилжсэн зэрэг ингээд ийм хэрэг асуудал байна. Сая таны хэлсэн энэ сургалтын асуудал бол тогтмол явагдах ийм асуудал буюу нийслэл, аймаг, сумын бүх шатлалын эмнэлгүүдэд салбарын холбогдох хууль тогтоомжид болон санхүүжилтийн шинэчлэлийн талаар тайлбарлан таниулах сургалтыг тогтмол зохион байгуулах, гүйцэтгэлийн санхүүжилтийг цаг тухайд нь алдалгүй авах нөхцөл боломжоор тухай бүр хангаж ажиллах гээд ийм нийтлэг ийм үүрэг даалгавар байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр тулгамдаж байгаа асуудлуудыг хянан шийдвэрлэх өөр ажлын хэсэг өөр үүрэг даалгавруудыг бид нар гаргах нь зүйтэй. Гагцхүү иймэрхүү асуудлуудыг энд нь хэвээр нь байлгаж бид нар хэрэгжилтийг хянаад яваад байгаа нь өөрөө буруу юм аа. Ийм учраас энэ асуудлуудыг давхардсан үүрэг даалгаврууд мөн түүнчлэн шинэ хуулиудаараа зохицуулсан асуудлуудыг энэ хяналтаас гаргаж энэ шинэ цаг тутамдаа үүсээд байгаа асуудлууд дээр зөв зохистой үүрэг даалгавруудаа өгөөд тэгээд зөв зохистой тайлагналтаа авъя аа л гэсэн ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр тэрнээс биш асуудал нь бол шийдэгдсэн гэсэн ойлголт бол огт биш гэдгийг та бас ойлгоорой.

Тэгэхээр энэ асуудал дээрээ үүссэн байгаа нөхцөл байдлыг тайлбарлаж ЭМЯ-аас таны асуултад хариулж болно. Гэхдээ энэ асуудал нь яг энэ 2021 оны 10 сарын 19-ний 5 дугаар тогтоолыг хүчингүй болгох аан биш ээ. Нөгөө хэрэгжилтээс тайлагналтаас хасах гаргах энэ саналтай огт холбоогүй юм шүү гэдгийг бас давхар хэлээдэхье.

**П.Ганзориг:** Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** Тэгээд энэ 3 асуудлын яах вэ 1 дүгээрт нь тэр өрхийн эмнэлгүүдийн нэгээр нь тооцсон төлбөрийн хэмжээ 2 дахин нэмэгдүүлэх талаар энэ бид аваад явж байгаа асуудал байгаа. Энийг хасахад санал татгалзах юм байхгүй.

Хоёр дахь нь Эм, эмнэлгийн эрсдэлийн газар нөгөө мэргэжлийн албыг тараасантай холбоотой Эрүүл мэндийн газар руугаа шилжсэн байцаагч нарын асуудал байгаа. Энийг ч яаж болно.

Гурав дахь асуудал. Харин эрүүл мэндийн салбарын маань тусламж үйлчилгээ санхүүжилтийн асуудлууд байнга ингээд яригдаад семинар хийж байхад бас ингээд үр дүн гарахгүй, байнга эргээд тусламж гүйцэд авч чадахгүй байгаатай холбоотой саналыг хэлж байгаа л даа Ариунзаяа гишүүн. Тийм учраас энийг бид нар бас юун дээр энэ тайлан дээрээ чиглэл өгч байгаад энийг тодорхой болгохгүй бол дахиад он дамжаад яриад байна. 2027 онд ярина тэгээд тийм учраас энэ асуудлаар онцгой анхаарах нь зөв байх гэж бодож байна.

**П.Ганзориг:** Үг хэллээ. Ганхөлөг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Ариунзаяа гишүүний ахалж байгаа ажлын хэсэгт байгаа учраас ажлын хэсгээс асуухгүй ээ. Хэрэг эрхлэхийн даргаас ерөнхий энэ процесстой холбогдолтой энийг сайжруулалт хийх зайлшгүй шаардлагатай юм байна лээ.

Хугацаа нь бүүр 2017 оноос авхуулаад энэ орж ирж байгаа энэ төслүүд ер нь хамгийн цаад талын хугацаа нь хэд байна гэдгийг бүгдээрээ нэг дахиад нэг харъя гэж бодож байна. Тэгэхээр ингээд энэ хугацаа байдаг юм уу тодорхой энэ шалгууруудаа хэрвээ хангаагүй бол автоматаар хасагдаад явдаг нэг иймэрхүү байдал руу орохгүй бол бид нар заавал ч үгүй ингээд механикаар энэ болгоныг ажлын хэсэг байгуулж байж бас ингээд хэлэлцээд явдаг нэг ийм байдал бас ажиглагдаад байна аа.

Тэгэхээр мэдээжийн тодорхой хугацаа нь өнгөрчихсөн хийгдэх ёстой ажлууд нь тодорхой цаг үеийн асуудлаас болоод хийгдэж чадаагүй гэдэг энэ үндэслэлүүд нь тодорхой байгаа асуудлуудыг жагсаалтаас ингэж гаргах тийм орон зайнуудыг нээх байдаг юм уу? Ер нь цаашдаа энэ процессыг илүү сайжруулах чиглэл дээр бид яаж ажиллах ёстой вэ? Ингээд нэг жил болгон л нэг хэдүүлээ ингээд нэг ийм нэг нэгэндээ 1 тайлан тавиад л тэгээд л тэр нь сайн муу гэдэг ийм нэг шүүмжлэлүүд гаргаад л ингээд л яваад байгаа. Тэгээд энэ нь үндсэндээ нэг ийм цаасан дээр нэг бичиглэлийн маягтай. Нөгөө талаасаа тайлан гаргах асуудал дээр бас би Засгийн газрыг бас ойлгохдоо илүү хялбарчлуулъя гэдэг ийм санаачилга гаргаад ажиллаж байгаа гэж ойлгоод байгаа. Тэгэхээр үүнтэйгээ ч бас үндсэндээ уялдаатай байж болох уу гэсэн ерөнхий 1 ийм асуулт эхлээд асуучихъя аа.

Хоёр дахь нь Соёлын яам, залуучуудын асуудлаар өнгөрсөн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо болохоос өмнөх буюу Нийгмийн бодлогын байнгын хорооны хамгийн сүүлийн хурлаар нэг жилийн өмнө, яг энэ залуучуудын асуудлаар 2017 онд батлагдсан энэ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн ажлын хэсгийг миний бие ахлаад ингээд тодорхой бас үүрэг даалгавруудыг Байнгын хорооны тогтоол болгож бас өгсөн.

Нэгд намрын чуулганаар одоо бүр хаврын чуулган хуралдаж байгаа шүү. Намрын чуулганаар яамнаас энэ суурь хуулийн үндсэндээ сайжруулалтыг оруулж ир ээ гэдэг ийм ерөнхий чиглэл өгсөн. Боловсролын зээлийн сантай холбогдолтой нэлээн олон агуулгуудыг бас өгсөн. Залуу малчдыг дэмжих чиглэлээр залуучуудын бас энэ нийгмийн асуудлыг үндсэндээ хөндсөн хөтөлбөр арга хэмжээнүүд хэрэгжүүлэх чиглэлээр, орон сууцын хөтөлбөр хийх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүд аваач ээ гээд маш тодорхой хугацаатай ийм арваад асуудлаар бас үндсэндээ үүрэг чиглэл өгсөн, тогтоол бас баталсан.

Тэгээд энэ хуулийн энэ тогтоолын хэрэгжилттэй холбогдолтой ямар ч бас тайлан мэдээллүүд бас яригдахгүй байгаа. Энийг би бас энэ дээр тодотгоод асууя. Одоо явж байгаа ажил нь ямаршуу түвшинд байна вэ, хэзээ хууль орж ирэхээр байгаа вэ?

**П.Ганзориг:** Хэрэг эрхлэхийн сайд Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын хяналт шалгалтыг сайжруулах хүрээнд 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулж үүний үр дүнд 2021 онд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдаж мөрдөгдөж байгаа. Ингээд 5 дахь жилдээ болж байна. Энэ хуульд өнгөрсөн онд яг зун орсон өөрчлөлтөөр энэ явцын гүйцэтгэлийн тайланг бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод жилд 2 удаа ийм танил тайлан танилцуулдаг. Ийм хуульд заалт орсон.

Бидний санал бол энэ бас яг тэдэн удаа, эдэн удаа гэдэгтэй бас биш юм шиг байгаа юм. Бид хамтдаа хүсэж байгаа зүйл бол Монгол Улсын Их Хурлын шийдвэр мэдээж 100 хувь л хэрэгждэг ийм байх ёстой. 100 хувь хэрэгждэг байхын тухайтад боловсруулалт нь ч тэр, давхцал хийдэл нь ч тэр тооцоо судалгаа нь ч тэр илүү үндэслэл бүхий шийдвэрүүд гардаг байвал аль аль талдаа хяналт тавьж байгаа талдаа ч тэр, хэрэгжүүлж байгаа талдаа ч тэр амар хялбар байх юм аа гэж ингэж үзэж байна. Зүгээр сая ингээд миний хувьд бас ажил аваад энэ хуулийн хэрэгжилт ч гэсэн шинэ тутам байна. Яг төсөвтэй адилхан л Улсын Их Хурлын бүх Байнгын хороодоор ингээд тайлан танилцуулаад явж байна.

Харин Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр танилцуулах энэ үед бол Байнгын хорооны бас гишүүд бол их ажил хэрэгчээр ялангуяа Ариунзаяа гишүүнээр ахлуулаад бас ажлын хэсэг гаргаад бас Байнгын хороо маань өөрийнхөө гаргасан шийдвэрт үнэлэлт дүгнэлт өгөөд ингээд Засгийн газартай бас би хамтарч ажилласандаа талархлаа илэрхийлье. Энэ бол бас бусад Байнгын хороонд ийм ажил хэрэгч хандвал их үр дүнтэй байх юм байна аа. Зүгээр сонсоод өнгөрөх биш. Зүгээр сонсож өнгөрөх талаас нь бодох юм бол би бол жилд 2 гэдэг бол надад их тийм дэмий санагдаад байгаа юм. Ер нь энэ чинь байнга л үнэлгээ хянаж байх ёстой. Бидний санал бол Засгын газар бол энэ доод шатдаа төрийн албан хаагчдаас авдаг тайланг бол бүгдийг нь цахимжуулж байгаа. Цаасаар авдгийг нь больж байгаа. Давхардсан тайлангуудыг нь багасгаж байгаа. Ерөөсөө жилд нэгхэн удаа тайлан авдаг л ийм л горим руу орон нутгийг бас шилжүүлж ийм асуудлуудыг 2 долоо хоногийн өмнө энэ тайлан үнэлгээ хийдэг аргачлалдаа бас Засгын газар тогтоолоор өөрчлөлт оруулсан. Ер нь бүхэлд нь ийм цахимжуулах ийм хэлбэрээр ажиллаж байгаа. Улсын Их Хурлаа мэдээж бид саналаа болгодог институт болохоос үүрэг даалгавар өгдөг институт биш. Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийг ер нь Засгийн газрын энэ мэдээллийн платформтой нэг болгочихвол яасан юм бэ гэсэн. Бид ийм саналтай байгаа.

Тэгээд байнга Их Хурлын гишүүд ч гэсэн Улсын Их Хурлын хяналт шинжилгээ үнэлгээний нэгж алба ч гэсэн хамтдаа. Ер нь гишүүд хүссэн үедээ ингээд гар утаснаасаа холбогдох шийдвэрүүдээ мэдээллээ аваад л явдаг байвал заавал энэ жилд тэдэн удаа эдэн удаа гээд ингээд ийм зузаан зузаан тайлан авчраад энэ олон албан хаагчдыг бас ингээд бүгдийг нь байлгаад байх ийм шаардлагагүй юм байна аа гэсэн ийм л бодолтой төрчхөөд байгаа юм.

**П.Ганзориг:** Нөгөө 2 дугаар асуулт дээрээ эхлээд Соёлын яамнаас хариултаа авчихъя тэгэх үү? Ганхүлэг гишүүний 2 дахь асуулттай холбоотой Соёлын яамны ТНБД. Индрийн микрофон дээрээс хариулъя.

**Б.Бат-Эрдэнэ:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Соёлын яамны ТНБД Бат-Эрдэнэ.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль нь 2017 онд батлагдсан. Одоо бол шинэчилсэн найруулгыг хийлгэх гээд ер нь бол ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Үнэлгээний бас хийлгэх ажлын хэсэг давхар ингээд ажиллаад үнэлгээ хийлгэх явц бол 25 хувьтай явж байгаа. Одоо үнэлгээ хийлгэж байгаа хууль дээрээ.

**П.Ганзориг:** Асуулт асуух гишүүд дээр Ганмаа гишүүнийг нэмчхээрэй. Тэгээд Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Тийм Энхбаяр сайдаас тодруулж байгаа нь одоо энэ ажлын хэсэг дээр яах вэ дийлэнх нь ингээд жагсаалтаас хасаж байгаа нь болохоор журам батална аа гэдэг ийм чиг үүрэг байгаа байхгүй юу. Тэгээд журмыг нь гаргаад ингээд баталчхаж байгаа юм. Ойлгомжтой энэнтэй хэн ч маргаад байх юм байхгүй. Тэгээд тэр журам батлагдсан уу? Батлагдсан.

Яг ийм асуудлыг бид нар ингээд нөгөө нэг жагсаалтаас хасах энэ боломж нь заавал ч үгүй ингээд ажлын хэсэг байгуулагдаад ингээд хуралдаад тэгээд ингээд аягүй олон процесс болж байж ингээд хасаад байна шүү дээ. Тэгээд энэ мэтчилэн ийм тодорхой ийм асуудлуудыг шууд жагсаалт нь хэрэгжсэн гэдгээр нь ингээд ангиллаар нь хасаад явдаг ийм механизмуудыг хийх чиглэл дээр бас та хэд маань энэ санал, дүгнэлт юмнууд дээр тусгаж байна уу? Дахиад тэр юу рийл тайм байнгын байна гэдгийг бас дэмжиж байна. Тэгээд энэ яг хэзээ ямар байдлаар яг хийгдэх гэж байгаа юм? Цахим платформ хөгжүүлээд байгаа юм уу? Өмнө нь бас нэг ийм юм бас яриад л байсан. Тэгээд тэр бас юу болсон юм бол. Тэрийгээ хөгжүүлээд явж байгаа юм болов уу гэдгийг дахиад тодруулъя.

**П.Ганзориг:** Нэмэлт нэмэлт минут өгье. Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** Би болохоор юу Соёлын яамнаас асууж байгаа нь болохоор залуучуудын асуудлаар гаргасан тэр тогтоолын хэрэгжилтийг асуугаад байгаа юм. Залуучуудын хөгжлийн тухай хуулийн үндсэндээ ажлын хэсэг дээр аль дээр энэ хуулийн хэрэгжилт нь хорин хэдэн хувьтай гэдэг ийм мэдээлэл юмнуудаа бол авчихсан. Нэг зайлшгүй энэ хуулийг үндсэндээ өөрчлөөд намрын чуулганаар орж ирэх ёстой гэсэн. Энэ орж ирээгүй байгаа. Дагаад маш олон бас тодорхой асуудлуудыг оруулсан. Нэг арваад ийм заалттай тогтоол байгаа юм аа. Тэгэхээр энэ тогтоолын хэрэгжилтийг 23 хувь гэж үзээд байна уу, эс үгүй бол энэ хуулийн юу хуулийн хэрэгжилтийг 23 гэж үзсэнийгээ дахиж та хэд маань яриад байна уу? Тэгэхээр тэр тогтоолын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр авч байгаа арга хэмжээгээ илүү тодорхой хариулаач ээ гэж хүсье.

**П.Ганзориг:** Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын энэ нөгөө ноднин жил Их Хурлын хяналт шалгалтын хуульд өөрчлөлт ороод энэний дагуу 2025 онд Их Хурлын 183 дугаар тогтоолоор энэ журмыг нь гаргачхаад байгаа юм. Тэгэхээр хэрэв Байнгын хороо асуудлыг хэлэлцээд Байнгын хороо бас холбогдох Улсын Их Хурлын шийдвэрт өөрчлөлт оруулах саналаа гаргах хэрэгтэй байгаад байгаа юм Засгын газар биш.

Тэгвэл бид бол одоо тийм л саналтай байгаад байгаа юм. Тэгэхээр 183 дугаар тогтоол дээр болохоор Засгийн газрын энэ Засгийн газар саналаа тавина аа л гэж байгаа юм. Хасах хяналтаас гарах саналаа тавина гэж байгаа юм. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бол 117 заалтыг хяналтаас хасъя аа гэдэг ийм санал гаргачхаад байгаа юм. Энэ журамд өөрчлөлт орж байж таны хэлж байгаа асуудал.

**П.Ганзориг:** Энхбаяр сайдад нэмэлт минут өгье.

**Б.Энхбаяр:** Тэр таны саналтай бол Засгийн газар одоо санал нэг байгаад байгаа юм. Бид болохоор нөгөө Их Хурлын тогтоолоор баталсан энэ журамд өөрчлөлт оруулъя гэдэг санал гаргах эрх бол Засгийн газарт байхгүй байгаад

байгаа юм. Улсын Их Хурлын бүтэц зохион байгуулалтын эрхлэх асуудлын хүрээний асуудлыг зөвхөн Улсын Их Хурал өөрөө мэддэг хууль тогтоомжтой учраас Улсын Их Хурлын эрх хэмжээний асуудал руу Засгын газар халтирч орохгүй байгаад байгаа нь ийм учиртай. Бид санал нэг байгаад байгаа юм.

**П.Ганзориг:** Соёлын яам нэмж хариулах уу? 2 дахь асуултад нь.

**Б.Бат-Эрдэнэ:** Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Тус Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжиж байгаа тогтоол бол залуучуудын боловсрол, залуучуудын эрүүл мэнд, залуучуудын нийгмийн баталгаа, хангамж гээд энэ салбар дундын асуудал болохоор ер нь удаашралтай явж байгаа. Энэ тогтоолын хэрэгжилт таны хэлж байгаагаар бол одоогийн байдлаар бид нарын үнэлж байгаагаар 23 хувьтай явж байгаа.

**П.Ганзориг:** Хэрлэн гишүүн асуулт асууя.

**Б.Хэрлэн:** Тэгэхээр бүрэн хэрэгжсэн, шийдвэрт заасан хугацаа нь дууссан үндэслэлээр хяналтын бүртгэлээс хасах тогтоолын жагсаалт дотор байгаа тэр 1.5 дээр бичигдсэн бүх шатын боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх суралцагчдыг нөгөө спортоор хичээллэх энэ бололцоог бүрдүүлэх энэ арга хэмжээг хэрэгжсэн гэж үзээд хасьяаа гэсэн байна л даа.

Тэгэхээр энэ дээр би энийг хасах цаг хугацаа нь болоогүй юм биш үү гэж би хэлэх гээд байгаа юм. Яагаад вэ гэхээр бас өнөөдөр энэ хэлэлцэж байгаа Улсын Их Хурлын Тогтоолуудын шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэсэн энэ тайлбар дээр энэ тайлан дотор өнөөдөр 563 сургуулийн сургалтын орчныг үнэл, үнэлгээ, дүгнэлт хийхэд тэнд биеийн тамирын спортын заал хүүхдийн нөгөө сургуулийн орчин энэ тэр нь болоод ирэхээр маш их эрсдэлтэй байна аа гэсэн ийм үнэлгээ дүгнэлтүүд хийсэн байгаад байгаа. Тэгээд энэ бол ер нь бид нар мэднэ шүү дээ. Өнөөдөр биеийн тамирын хичээл дээр бараг ер нь бүртгэл хийгээд байж байтал нөгөө цаг нь дуусаад явчихдаг 2, 3 анги зааландаа цуг бөөнөөрөө хичээл нь ордог ийм болчихсон ийм цаг үе.

Тэгэхээр энэ тогтоолыг бүрэн хэрэгжсэн гэж юу гэдэг юм. Нөгөө хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмж авснаар бид нар энэ бүр бүрэн хэрэгжсэн гэж үзээд энийг хойш нь тавьчих боломж, ер нь тавих уу яах вэ гэдгийг бид нар бас эргэж хармаар юм шиг байна. Тэгээд одоо энэ дээр бас нэг юм байна л даа. Одоо энэ Боловсролын яамны ТНБД байгаа дээр асуухад ер нь сургалтын орчны талаарх норм нормативыг Боловсролын сайд, Сангийн сайд, түүнчлэн Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар энэ норм нормативыг тогтоох ёстой. Энэ бол 2021 оны ер нь 2023 онд батлагдсан Боловсролын тухай хуульд тусгагдсан ийм заалт байгаа.

Өнөөдөр 3 жил болоод байхад энэ норм нормативыг тогтоогоогүй. Тийм учраас биеийн тамирын спортын заал энэ тэр бол одоо энэ дээр ингээд хэрэгжсэн гэж үзээд, дүгнээд гаргах арга байхгүй нөхцөлтэй байгаа гэдгийг бол бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр энэ хамтарсан тогтоол шийдвэр нь хэзээ гарах юм бэ? Норм нормативыг хэзээ тогтоох юм. Ер нь энэ биеийн тамир спортын заалны нөхцөл байдал хүнд байгаа үед энийг хэрэгжсэн болсон гэж үзээд одоо энэ хяналт

хянах ёстой энэ тогтоолын жагсаалтаас гаргах нь зөв үү? Эсвэл бид нар ахиад энийг цааш нь энэ дээр анхаарал тавихын тулд бид нар яах ёстой юм. Энийг асуух гэсэн юм. Ажлын хэсэг бас Боловсролын ТНБД 2-аас асууя.

**П.Ганзориг:** Ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүн хариулъя.

**А.Ариунзаяа:** Сая Хэрлэн гишүүний хэлж байгаа ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021 оны 5 сарын 25-ны 5 дугаар энэ тогтоолыг хэлж байна аа. Энэ бол өөрөө хугацаатай өгөгдсөн үүрэг даалгавар буюу БСШУС-ын Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж Монгол Улсын Засгын газар Оюун-Эрдэнэд чиглэл болгосугай. 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн ийм суралцагчдын энэ хоолны юуг шийдвэрлэх 2021-2022 оны хичээлийн жилээс шаардагдах хөрөнгийг нь шийдвэрлэх 2021 онд батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх, 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан хавсралтаар 2022 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган батлуулах гэх зэрэг ийм асуудлууд байгаа байхгүй юу. Би тэгээд нөгөө гишүүдэд бас юу гэж хэлээд байна вэ гэхээр өнөөдөр тулгамдаж байгаа асуудлуудыг 2021 оны тогтоолоор бид нар биелэлтийг нь нэхээд байгаа нь өөрөө буруу байгаад байна аа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах Улсын Их Хурлын 72 шийдвэрийн 486 заалтаар одоогийн байдлаар тайлан мэдээллүүд ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дотроо бол маш олон давхардсан шинэчилсэн хууль эрх зүйн орчны энэ хэсгийнхээ дагуу бас ажил үүргүүд нь явагдаж байгаа ийм зохицуулалтууд байгаад байгаа учраас энэ 486 энэ асуудал дотор сая таны хэлсэн асуудлууд ч гэсэн бас давхар үүрэг даалгавар өгөгдчихсэн ийм тогтоолууд байгаа. Тэгэхээр 2021 оны энэ 5 сарын энэ тогтоолыг бол тодорхой хэмжээнд энэ хэрэгжилтээс хасах саналыг бол гаргаад байгаа юм аа ажлын хэсгийн хүрээнд. Тэгээд цаашлаад бол өнөөдрийн хууль тогтоомжийнхоо хүрээнд өгөгдөөд байгаа үүрэг даалгавар дотроо давхардсан байдлаар ямар даалгавар байна вэ гэдгийг магадгүй Боловсролын яамны ТНБД ийм даалгавар байгааг та санаж байвал бас хэлчих үү? Энэ 489 дотор энэ давхардсан даалгаврууд бол байгаад байгаа юм.

**П.Ганзориг:** Боловсролын яамны ТНБД нэмж хариулъя.

**Т.Ням-Очир:** Хэрлэн гишүүний асуултад хариулъя аа.

Тэгээд сая яг Ариунзаяа гишүүний хэлж байгаа 2023 онд боловсролын багц хуулиуд шинэчлэн батлагдсан. Биеийн тамир спортын хууль шинэчлэгдсэн. Тэгэхээр энэ хууль эрх зүйн орчинд энэ хүрээнд Боловсролын ерөнхий хуулийн 38, 39, 40, 41 дүгээр зүйлүүд дээр боловсролын салбарын санхүүжилтийн эх үүсвэрүүдийг яг тодорхой тусгачихсан. Энэ хүрээндээ тодорхой дүрэм журам хөрөнгө оруулалтын бодлогууд явж байгаа учраас нөгөө сая Ариунзаяа гишүүний хариулдгаар агуулгын хувьд давхардсан энэ зүйл заалтуудыг тухайн үеийнхний хэрэгжилтээр нь биелэлтийг нь хаагаад шинэ хууль эрх зүйн орчныхоо хүрээнд хяналтад заалтуудаа аваад явна гэсэн ийм байдлаар хариулт хийе гэж бодож байна.

**П.Ганзориг:** Хэрлэн гишүүн тодруулъя.

**Б.Хэрлэн:** Тэгэхээр би нөгөөд сургуулийн хүүхдийн хоолны хөтөлбөр биш биеийн тамир спортоор хичээллэх боломжийг нь бүрдүүлэх тухай би асуугаад байгаа юм. Биеийн тамир спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой энэ Байнгын хорооноос гарсан тогтоолын хэрэгжилтийг хэрэгжсэн гэж үзээд хасъяаа гээд ингээд явчихсан байна л даа. Тэгэхээр биеийн тамирын хичээл гэдэг бол сургуулийн насны хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх хамгийн гол зүйл бол биеийн тамирын хичээл. Биеийн тамирын спортын танхим байгаад байгаа юм. Заал байгаад байгаа юм. Тэгэхээр сая хийсэн таны эрсдэлийн үнэлгээгээр энэ чинь маш хангалтгүй гээд гараад ирчихсэн байгаад байгаа. Ийм үед энэ биеийн тамирын спортын асуудлыг хойш нь тавиад хэрэгжсэн гээд хаагаад ингээд яваад байх юм уу би эсвэл бид нар ахиад өөр өөр чиглэл үүрэг даалгавар өгөх ёстой юм уу яах вэ? Тэгээд дээр нь 3 яамны хамтарсан ийм тогтоол гарах ёстой. Норм нормативыг тогтоосон энэ стандартыг тогтоосон ийм шийдвэр гарах ёстой. Энэ чинь хэзээ гарах гээд байгаа юм бэ? 3 жил өнгөрөөд байна шүү дээ. Одоо Боловсролын хууль батлагдаад.

**П.Ганзориг:** Боловсролын яамнаас хариулах уу?

**Т.Ням-Очир:** Одоо бол яг сургууль ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага, стандарт, ЕБС-ийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ, ерөнхий шаардлага, СӨБ-ын сургалтын байгууллагын ерөнхий шаардлага, сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага гэсэн энэ шаардлагууд бол албан ёсоор батлагдчихсан. Ингээд явж байгаа. Энэ дотор одоо нөгөө цэцэрлэг, сургууль, дотуур байрны ус, ариун цэврийн эрүүл ахуйд тавигдах норм шаардлага. Мөн бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт орох илүү орчныг бүрдүүлэх гээд энэ 2019, 2020, 2025 онд батлагдсан ийм норм нормативууд батлагдсан байгаа. Шинэчлэн батлах норм нормативууд дээр ажиллаж байгаа.

**П.Ганзориг:** Ганмаа гишүүн асуулт асууя.

**Д.Ганмаа:** Сайн байцгаана уу? Энд 2019, 2020 оноос эхлээд тэгээд хэрэгжилт нь баталчихсан зүйлүүдийг ч юм уу эсвэл хугацаа нь өнгөрчихсөнийг хасъяа гэдэг саналтай бол санал нэгдэж байна. Зүгээр яагаад заримууд нь огт хэрэгжилт нь хангагдаагүй нэг 2, 3 асуудлууд жишээлбэл эрүүл мэнд дээр ч юм уу хүүхэд хамгааллын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилт дээр байна л даа. Энд хүний амь насанд аюултай хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин эмгэгийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд баталнааа гээд орчихсон. Энэ нь тэгээд эрүүл мэндтэй ч, хүүхэд хамгаалалттай ч холбоотой салбар дамнасан асуудал учраас ингээд удаад хүлээгдээд байна уу эсвэл энэ дээр нөгөө бодлого хэрэгжүүлж гаргах тийм арга аргачлалыг юу гэдэг юм бэ дээ чадавх дутагдаж байна уу? Эсвэл тэр санхүү мөнгө төсөв нь болоогүй юу? Жишээлбэл нийгмийн эрүүл мэндийн хэсэг дээр ч гэсэн энэ нэг хэрэгжилт нь хангагдаагүй 4, 5 гэчихсэн бага хуваарь гарчихсан тоонууд байгаад байсан. Тэр мөн санхүүжилт нь гол нь тавигдаагүйгээс болсон уу үгүй юу 2 дахь асуулт нь.

Хэрвээ тийм бол уялдаатай ажиллаж одоо яг нэг зарчмын зөрүүтэй санал өгөх боломжтой үеэр нь цаг хугацаанд нь тааруулж оруулж ирж нэг уялдаатай ажиллахгүй бол миний санал бол одоо 4, 5, 6 жилийн дараа бас энийгээ ингээд л яриад сууж байх нөхцөл байдалтай байгаад байна л даа. Тэр яагаад энэ хэрэгжилт

нь хангагдахгүй удаан ийм чухал юмнууд нь хаягдаад байгаа юм болоо гэдэг дээр нэг хариулт авъя.

**П.Ганзориг:** ЭМЯ-аас Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

**Н.Эрдэнэбаяр:** Ганмаа гишүүний асуултад хариулъя.

ЭМЯ Эрдэнэбаяр. Энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний энэ хэрэгжилтийн асуудлыг гаргах дээр бол одоо 2 талтай юмнууд бас байгаад байгаа.

Нэгдүгээрт нь бас энэ санхүүжилттэй холбоотой бас энэ зүйлүүд бол байгаа. Тэгээд энэ дээрээ бид нар бас тодорхой хэмжээнд анхаарч сая бас энэ хуулийн бас шинэчлэн найруулагатай холбоотойгоор бас энэ дээр нэлээн идэвхтэйгээр бас энэ дээр яаж зохицуулах вэ гэдэг дээр бас бид нар ярилцаж байгаа. Тийм шинэчилсэн найруулга.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль дээр энэ ховор өвчний аргачлал батлах дээр болохоор нөгөө батлагдсан гэдгээрээ л явж байна уу гэж ойлгоод байгаа. Би бас тэгэхдээ энийг бас тодруулж ярихгүй бол яг шууд хэлж чадахгүй байгаад байна. Тийм энэ нөгөө салбар дундын юунууд дээр зохицуулагдаж байгаа болохоор.

**П.Ганзориг:** Ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүн нэмэлтээр хариулъя.

**А.Ариунзаяа:** Ганмаа гишүүнд баярлалаа. Яг энэ хэрэгжээгүй гэсэн одоо энэ чинь нөгөө энэ манай Байнгын хорооноос өгөгдөөд байгаа 72 шийдвэрийн 486 заалт дотроо цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон давхардсан гэдэг юм уу хэрэгжилтээс юу гэдэг юм нөгөө тайлангаас нь хяналтаас хасах энэ шийдвэрүүдийг бид нар ингээд хасчихлаа. Цаана нь юу үлдэж байгаа вэ гэхлээр ердөөсөө хэрэгжих боломжгүй хэрэгжээгүй гэсэн ийм асуудлууд байна. Мөн түүнчлэн зохион байгуулалтын улмаас удааширсан байгаа ийм асуудлууд байгаад байна гэх мэтчилэн үлдэж байгаа тогтоолууд дээрээ бид нар бас үнэлгээ хийгээд юуг нь илүү сайжруулж нэмэх ёстой юм. Ямар үүрэг даалгавруудад дахиад өөрөөр өөрчлөн найруулах ёстой юм гэд гэдэг дээрээ дараагийн энэ ажлуудаа бас төлөвлөж явах ёстой юм байна лээ шүү гэдгийг бас давхар хэлье.

**П.Ганзориг:** Гишүүд асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Энэ Бум-Очир гишүүний юу ороогүй. Бум-Очир гишүүн асуулт асууя.

**Д.Бум-Очир:** Баярлалаа. Гол нь энэ нэг урт хугацаанд хийгдэх шаардлагатай зарим гишүүд бас хэлж байна. Ганмаа гишүүн хэлж байна. Хэрлэн гишүүн хэлж байна. Ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүн бас хэлээд байна. Цаашид тодорхой хэмжээгээр магадгүй дараагийн шатад үргэлжлүүлэх шаардлагатай төслүүд байх шиг харагдаад байна аа. Тэгээд энийгээ бол бас хариуцлагатайгаар хариуцаж байгаа чиглэлийн яамд нь тэр ажлуудыг үргэлжлүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Өөрөөр хэлбэл энд хасаж байгаа ажлууд маань тодорхой хугацаанд тодорхой түвшинд хийгдээд хэрэгжсэн гээд хаагдаж байж болно оо. Тэрийг бол ойлгож байна. Гэхдээ бодитой үр дүнд хүрэхийн тулд өнөөдөр мөн нийгэм цаг хугацааны хувьд нийгэм дээр хэрэгцээ шаардлагатай байгаад байгаа.

Хэрэгцээ шаардлага нь цаашаа магадгүй өөр түвшинд үргэлжилж байгаа, эс үгүй бол одоо үр дүнг нь илүү өөр аргаар үр дүнд хүргэж сайжруулах шаардлагатай ажлууд байгаад байгааг анхаараарай гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна.

Түүнээс биш ер нь бол үндсэн санааг нь зарчмын хувьд дэмжиж байгаа шүү гэдгийг хэлье.

Жишээ нь миний түрүүний яриад байдаг тэр өв соёлын асуудал дээр бол хилийн чанад дахь Монголчуудын сургалтын төв, Соёлын төв дээр ямар асуудал байдаг вэ гэхээр 1 дүгээрт тэр сурах бичиг бол гараагүй байгаа юм аа. Яг Монгол хэлийг 2 дахь хэл болгож заахад одоо хэрэглэх сурах бичиг түүнчлэн Монгол хэлтэй холбоотой Монгол хэлний заах арга зүйн стандарт энэ тэр гэсэн ийм зүйлүүд байгаад байгаа юм аа.

Нэгдүгээр ийм нэг зүйл байна. Түүнчлэн энэ хилийн чанадад байгаа хэл соёлын яг сургуулиуд биш шүү. Бас төвүүд маань ямар хүсэлт тавиад байгаа вэ гэхээр тэдэнд маш бага хэмжээний учиргүй олон зуун юм уу олон тэрбум төгрөгийн дэмжлэг биш юм аа. Жишээ нь одоо 7 хоногт 2 удаа тэр гэрт нь ойрхон байгаа янз бүрийн нийтийн соёлын төв маягийн байгууллагуудаас үгүй ээ коммунити центр гэж хэлж байгаа юм даа. Манайхаар соёлын төв шиг байгууллагууд тэндээсээ нэг 7 хоногт 2 удаа ч юм уу нэг удаадаа 1, 2 цагаар ч юм уу нэг өрөө танхим түрээслээд нэг багш тэнд хүүхдүүдэд Монгол хэл заагаад байгаа юм л даа. Тэр багш юу хүсээд байгаа вэ гэхээр бидэнд сурах бичиг хэрэгтэй байгаад байна аа. Тэгэхдээ одоо та бид нарын сургуульд сургаж байгаа цагаан толгой тэр биш Монгол хэлийг хоёрдогч хэл болгож зааж байхад хэрэгтэй сурах бичиг. Мөн түүнд холбоотой тэдний насны хүүхэд хэдэн үгийн сандаа Монгол үг нь хэдэн үг мэдэж байх ёстой вэ? Ямар ямар үгийг мэдэж байх ёстой вэ гэдэг ч юм уу ийм стандартууд байгаад байдаг. Энийгээ одоо нөхдүүд маань нэхээд байдаг. Түүнчлэн олон ажил хийгдсэнийг би бол ойлгож байна аа. Би өөрөө ч заримыг нь ерөнхийдөө мэдэж байна.

Бас хэд хэдэн яамдууд хамтарч хийх шаардлагатай бол Боловсролын яам, Соёлын яам, Гадаад яам. Өнөөдөр Гадаад яам энд байхгүй байхгүй байх шиг байна аа. Бас нэг хүсэлт байдаг. Энэ багш нараас тодорхой хэмжээгээр санхүүжилтийн дэмжлэг байвал зүгээр байдаг юм. Жишээ нь тэрийг тэр сургалтын юм уу анги танхимаа түрээслэхэд 7 хоногт 2 удаа нэг удаадаа 2, 2 цагаар ч юм уу, 3, 3 цагаар түрээслэлээ гэхэд тэр цагаар мөнгийг нь өгөөд явдаг ийм юмнууд ч байдаг. Зарим нь ЭСЯ-ан дээрээ өрөө танхимын бололцоотойнууд нь өрөө гаргаж өгөөд явж байгаа. Өрөө танхим гаргаж өгөх бололцоогүйнүүд нь бид одоо нэг цөөхөн мөнгө л байвал болчих гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр иймэрхүү байдлаар хялбархан зохицуулж болох ажлууд байгааг холбогдох чиглэлийн яамдууд нь анхааралдаа аваарай. Тодорхой сургалтын төвүүдэд мөнгө төгрөг өгсөн дэмжлэг үзүүлсэн гэдэг. Тэрийг бол би мэдэж байгаа. Тийм мэдээллийг бол авсан байгаа. Маш олон сургалтын төвүүд бий. Хүүхдүүд нь Монголоор ярьж чадахаа болиод ирэхээр иргэд чинь санаа зовж эхлээд Монгол хэлтэй нэг нь очоод тэнд хичээл заагаад, Монгол хэлний багшийн боловсролтой ч юм уу эс үгүй бол цаг заваа гаргаад Монгол хэлний багш биш улсууд хүртэл хичээл заагаад явдаг. Жоохон жоохон дэмжлэг байдаг юм. Энийг та бүхэн судалж үзээд, танилцаад, санал хүсэлтийг нь хүлээж аваад боломжийн дэмжлэг үзүүлээд асуудлыг нь шийдэх боломж бий шүү гэдгийг хэлье.

**П.Ганзориг:** Ганхуяг гишүүн үг хэлье.

**М.Ганхүлэг:** Улсын Их Хурлаар энэ баталж байгаа шийдвэрийн бас энэ биелэлт дээр яах вэ? Нэг сууриар нь нэг сайжруулалт хийх зайлшгүй шаардлагатай бас байна аа. Яг л нэг ийм л уламжлалт байдлаараа ингээд нэг тодорхой хэдэн ийм бас ийм цаасууд өгөөд л энийгээ хэдүүлээ жил тойрч яриад л нэг тийм асуудлаа нэлээн ийм цогцоор нь харах яг энэ хэрэгцээ, хэрэгжээгүй гэдэг энэ асуудлууд руугаа гүн орохоосоо илүүтэй тэр учир шалтгаануудаа илүү тодорхойлох тэр журмаа шинэчлэх энэ тэр гэдэг нэг ийм үндсэндээ ужгирсан асуудлуудыг бид нар зайлшгүй бас ярихгүй бол бас болохгүй байгаад байна аа. Тэгээд энэ Цахим Монгол болох тухай асуудлууд ярьж байна. Тайлан төлөвлөгөө янз янзын юм гаргасаар байгаад дийлэнх цагаа өнгөрүүлж байгаа тухай бас асуудлууд ярьж байна.

Тэгэхээр эдгээр энэ асуудлуудыг үндсэндээ бол нэгтгээд нэлээн сайн асуудлыг судлаад тэгээд тэр их өгөгдөл, дата бүрдүүлэлт, рийл таймаар тэр бүх мэдээллээ харах энэ тэр гэдэг асуудлууд дээрээ та бүхэн маань бас нэлээн сайн анхаарч ажиллаач ээ. Энхбаяр сайд бас яг энэ асуудал дээр нэлээн онцгой анхаарал хандуулаад ингээд зөвхөн Их Хурлын гишүүд биш иргэд олон нийт, яг тухайн салбарын мэргэжилтнүүд хүртэл эндээс гарч байгаа энэ бодлого шийдвэрүүд саналаа өгч байгаатайгаа адилхан хэрэгжилтийн явц дээр нь бас үндсэндээ хараад ингээд явж байдаг нэг ийм байдлуудыг хэрвээ бий болгох юм бол хаа хаанаа бид бүхэн илүү тийм тодорхой хийж байгаа ажил, хийж болохгүй байгаа асуудлуудаа ингээд хараад явах нэг ийм нөхцөл бас бүрдэх гээд байна аа. Нэг л энэ явж байгаа энэ процесс маань хоцрогдсон байгаад байна. Нэг л тийм нэг болохгүй яг ийм хуультай юм аа энэ хуулийнхаа дагуу л явж байна аа гэдэг нэг ийм хандлагаар үндсэндээ ингээд хандаад ямар ч тийм шинэчлэл, дэвшил тэгээд энийг, тийм өөр болгоё энэ тэр гэдэг ийм хүсэл тэмүүлэл энэ тэр ямар ч тийм юм мэдрэгдэхгүй тэгээд ингээд нэг нэгнийхээ зүгээр нэг цагийг ийм үрсэн, нэг хуурсан нэг ийм л байдалтай л яваад байх шиг л ийм мэдрэмжүүд төрөөд байна л даа.

Тэгэхээр энэ дээр бас та бүхэн маань нэлээн сайн анхааралтай ажиллаач ээ. Илүү дэвшилтэт болгох, илүү хялбарчлах энэ боломжуудыг бас хийгээч ээ гэдгийг бас голчилж бас хэлмээр байна аа. Тусгайлсан тэр тогтоолын бас асуудлуудаа ингээд яривал зөндөө л юм болж байгаа юм. Тэгээд тэр залуучуудын асуудал дээр ингээд үндсэндээ ерөөсөө бараг хараагүй, тэрийг үндсэндээ дүгнээгүй шахуу л байна шүү дээ. Ямар ч төсөв тавьдаггүй. Ямар ч хэрэгжих боломж бололцоог нь олгодоггүй. Тэгээд 1 иймэрхүү байдалтай л үндсэндээ энэ ажлууд үндсэндээ явж байна аа.

Дараа дараагийн сайд нарыг байдаг юм уу тодорхой албан тушаалтнуудаа дэмждэг, урамшуулдаг тэр механизм нь тэр үндсэндээ дата мэдээлэл дээрээ энэ ажлын үр дүнгээрээ шууд харагдаад ингээд байж байдаг л баймаар байгаа байхгүй юу. Тэгэхгүй ингээд үндсэндээ мөнхийн юм шиг бүх Засгын газар солигдоход байнга байж байдаг сайд нар байж л байдаг. Тэгээд үндсэндээ тэрийг нь тэр ажлын шаардлага шалгуураар нь яг яаж үнэлж үнэлж байгаа юм, тийм бодитой энэ тэр юмнуудыг гаргаж ирэхийн тулд бидний энэ тайлан мэдээлэл юмнууд энэ дата дээр суурилах илүү ухаалаг болох нь өөрөө чухал болно оо гэдгийг л дахин дахин хэлье дээ.

**П.Ганзориг:** Гишүүд бас чухал саналууд хэлж байна шүү. Тэгээд яг энэ гүйцэтгэлээ бас дүгнэхдээ тухайн яам сайд нарын ч гэсэн ажлын бас үнэлэлт

дүгнэлт болж харагддаг байдлаар ингээд явах нь бол чухал байна аа гээд. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд Байнгын хорооны гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалттай. Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос, 14 гишүүн дэмжиж, санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа.

Ингээд тайлангийн бас үр дүнг хэлэлцүүлж тогтоолын төслөө танилцуулсан ажлын хэсгийн ахлагч Ариунзаяа гишүүн, нийт бас ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлье.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Байнгын хорооныхоо нийт гишүүдэд баярлалаа.

16.16 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА